

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.05.05

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн IX хуралдаан 04 дүгээр сарын 05-ны өдөр хуралдаж 5 асуудал хэлэлцэж 6 тогтоогыг баталлаа. Үүнд:

-Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнг хэлэлцэн “Хангалттай” үнэлгээ өгч хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээ авч ажиллахыг даалгалаа.

-Аймгийн 2018 оны төсөвт тодотгол хийж, урьд оны нэмэгдлийг тусган баталлаа.

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган төрөөс иргэд, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлэх бодлогын хүрээнд Хөтөлийн “Цемент шохой” ХК-ний төлөгдөөгүй татварын өрөөс Сүхбаатар суманд баригдах 120 айлын орон сууцны барилга барих арга хэмжээнд зарцуулах асуудлыг шийдвэрлэж, зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн хэрэгцээнд авах тухай асуудлыг хэлэлцэн гол, мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалгүй 56 байршлын 1330,3 га газрыг бичил уурхайн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хэрэгцээнд авлаа.

-Төрөөс зардлыг хариуцах мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээг баталж, малын халдварт шөвөг яр, адууны томуу, сахуу зэрэг өвчний урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг аж ахуй нэгж, малчид иргэдээс гаргуулах тухай тогтоолыг баталж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааны тайланг сонсож “Хангалттай” гэж үнэллээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж ИТХ-ын IX хуралдаанаар хэлэлцэх асуудлууд болон Шаамар сумын “Бүжинхэн” 18 дугаар цэцэрлэгийн 50 жилийн ой, мөн сумын МСҮТ-ийн 60 жилийн ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай болон зарим иргэдийг шагналд уламжлах асуудлыг хэлэлцэж тогтоолыг баталлаа.

2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хуралдааныг 4-р сарын 3-нд зохион байгуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлагууд оролцож, агентлаг тус бүр цаг үеийн ажил арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийж, аймгийн Засаг дарга үүрэг чиглэл өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, United Management Consulting хамтран аймгаас “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан “Хөрөнгө оруулалт, эдийн засгийн чуулга, уулзалт”-ыг энэ сарын 27-ны өдөр аймгийн төвд зохион байгууллаа. Чуулган аймгийн хөрөнгө оруулалтын гарц, эдийн засгийн төрөлжилт-аялал жуулчлал, шинэ технологи-инноваци-ХАА, ухаалаг ирээдүй-боловсрол, эрүүл мэнд гэсэн дөрвөн нэгдсэн хуралдаанд тулгуурлагдан явагдаж, “Сэлэнгэ аймгийн хөгжлийн ирээдүй” сэдвээр Засаг дарга Ш.Оргил үндсэн илтгэлийг

тавьснаас гадна ОХУ-ын Дархан-Уул аймаг дахь Ерөнхий консул А.Ц.Доржиев, Кувейт улсын ЭСЯ, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/-аас мэндчилгээ дэвшүүлсэн бол Герман улсын GIZ-ийн эдийн засгийн бодлого, хувийн хэвшлийн хөгжлийн хэлтсийн дарга Др.С.Курц, Үндэсний хөгжлийн газрын судалгаа, шинжилгээний албаны дарга А.Мөнхболд, мөн газрын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга Л.Мөнбат, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гүйцэтгэх захирал Б.Лакшми, ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн зөвлөх А.Мөнхжин, GIZ-ийн ЭТИС хөтөлбөрийн захирал Др.Ш.Ханселманн, Швейцарь улсын иргэн, доктор Паскал Гэйрч, GIZ-ийн ЭТИС хөтөлбөрийн дэд захирал О.Батболд, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, “Гацуурт” ХХК-ийн захирал Л.Чинбат, “Reinkle” компанийн Монгол дахь төлөөлөгч, “Торсг ор” ХХК-ийн захирал Э.Жаргал, Хүлэмжийн фермер хөгжүүлэгчдийн нийгэмлэгийн тэргүүн Х.Алтанцацралт, “Сэлэнгийн Герефорд” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Галсанням, аймгийн ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр нарын хүмүүс илтгэл тавьсан. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг дарга 13 байгууллага, 1 иргэнтэй хамтран ажиллах гэрээ, санамж бичигт гарын үсэг зурж 7.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймагтаа татаж чадлаа. Тухайлбал: Германы GIZ-ийн ЭТИС хөтөлбөрийн газартай “Дижитал буюу цахимжсан хэлбэрээр орон нутгийн цогц хөгжлийн түншлэлийн талуудын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх зорилгоор 17 суманд цахим хурлын орчин үеийн төхөөрөмж суурилуулах, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, иргэдэд зориулсан сургалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, Сэлэнгэ утасны аппликейшнийг хөгжүүлэх” гэрээнд “Сөүл” групптэй Мандал суманд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Аялал жуулчлалын цогцолбор байгуулах хамтын ажиллагааны санамж бичигт “ММС” ХХК-тай Жавхлант суманд нэгдсэн халаалтын төв, цэвэр усны шугам барих 1 тэрбум төгрөгийн хамтын ажиллагааны гэрээнд Швейцарь улсын иргэн Паскал Гейртсэй Сүхбаатар суманд цанын бааз байгуулах санамж бичигт Монланс тур” ХХК-тай Жавхлант сумын Ерөө голын Ногоон тохойд “Жавхлант Эко тур” жуулчны бааз байгуулах 2.6 тэрбум төгрөгийн хамтын ажиллагааны гэрээнд “Болд төмөр ерөө гол” ХХК-тай Ерөө сумаас Бугант тосгон хүртэл 70 км хайрган хучилттай зам барих хамтын ажиллагааны санамж бичигт “ТопКроп” ХХК-тай Сэлэнгэ аймгийн газар тариалангийн салбарт АНУ-ын усалгааны сүүлийн үеийн шилдэг тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, усалгаатай тариаланг нэмэгдүүлснээр Сэлэнгэ аймгийн ургацын эрсдэлийг бууруулах, усалгаатай тариаланг түшиглэж эрчимжсэн газар тариалан мал аж ахуй хосолсон фермерийн аж ахуйг хөгжүүлэх, усалгаатай тариалангийн чиглэлээр АНУ-ын Небраска мужаас агрономич урьж ажиллуулах, Сэлэнгийн хөдөө аж ахуйн залуу боловсон хүчнийг тус мужийн фермүүдэд дадлагажуулах зэрэг ажлуудыг хамтран гүйцэтгэх “Сэлэнгэ-Усжуулалт” төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичигт Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуультай Сэлэнгэ аймгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах, сургах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээнд Буриад Улсын их сургуультай Сэлэнгэ аймгийн хүүхэд залуусыг тус сургуульд сургах, ОХУ-ын их дээд сургуульд элсэхэд бэлдэх, орос хэлний сургалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээнд ибирийн хэрэглээний хоршооллын их сургуультай Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийг бэлтгэх чиглэлээр Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээрх сургуулиудад мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг явуулах, сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээнд, “Карьер хөгжлийн төв”-тэй Сэлэнгэ аймгийн иргэд залуусын зан төлөв, авьяас сонирхол хандлага, ур чадварыг технологийн дэвшил ашиглан дэлгэрэнгүй тодорхойлж, карьер хөгжлийн сургалт, зөвлөгөө өгч ажил мэргэжлээ зөв сонгоход нь туслах болон ажил амьдралын сорилтуудыг амжилттай даван туулах төлөвлөгөөтэй, өрсөлдөх чадвартай, баялаг бүтээгч Сэлэнгийн иргэнийг бий болгох зорилгоор “Карьер хөгжлийн төв” байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичигт, Хууль зүйн туслалцааны төвтэй Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны мэдээлэл, туслалцаа үзүүлэх, жишиг

хууль зүйн туслалцааны төвийг байгуулж, техник тоног төхөөрөмжөөр хангах хамтын ажиллагааны санамж бичигт тус тус гарын үсэг зурсан. Мөн энэ үеэр аймгийн баялаг бүтээгчдийн төлөөлөл өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

Япон улсын Шизуока мужийн төлөөлөгчид энэ сарын 17-нд тус аймагт ажлын айлчлал хийж, төмс, хүнсний ногооны салбарт мэргэжилтэн бэлтгэх, төмс, хүнсний ногооны техник хангамжийг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах, үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, шинэ сорт туршин үйлдвэрлэлд нэвтрүүлэх, жимс, жимсгэнэ гадаад зах зээлд худалдан борлуулах тал дээр хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас 2018 оны хаврын тариалалтын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Хөдөлмөрийн баатар Ш.Мардаан, ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Болорчулуун, ХХААХҮЯ-ны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн гүйцэтгэх захирал н.Үнэнбат, ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр, Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн дэд захирал доктор рн Б.Баатарцол, Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн салбарын эрхлэгч рн М.Отгонсүрэн, ОХУ-ын Буриад улсын ургамал хамгааллын хүрээлэнгийн захирал рн Мардваев Намжил Бадмаевич, аймгийн Хөрөнгө оруулалт Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Бүрэнжаргал, Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга М.Рэгзэдмаа нарын албаны хүмүүс, газар тариалан эрхлэгчдийн төлөөлөл, сумдын ХАА-н тасгийн агрономичид оролцож, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, технологийн талаар харилцан санал солилцлоо.

Энэ онд аймгийн хэмжээнд нийтдээ 180 гаруй мянган га талбайд тариалалт хийх төлөвлөгөөтэйгөөс 145 орчим мянган га-д үр тариа, үүнээс улаанбуудай уриншинд 128000 га, гуурсанд 12000 га, бусад үр тариа 2300 га, тэжээлийн ургамал 15000 га, тосны ургамал 28000 га, төмс 2600 га, хүнсний ногоо 2535 га талбайд тариалахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймгийн малын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, “Мал амьтны эрүүл мэндийн тухай”, “Малын генетик нөөцийн тухай” хууль батлагдаж энэ оны 06-р сарын 01-нээс мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан мэдээлэл өглөө.

”Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2018” арга хэмжээний нээлтийг 4-р сарын 04-ний өдөр зохион байгууллаа. 6 дахь жилдээ өрнүүлж байгаа энэ удаагийн арга хэмжээ нь “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлцгээе” уриан дор явагдана. Нээлтийн арга хэмжээнд аймгийн удирдлагууд болон төр төсөв, аж ахуйн нэгж байгууллагын 400 гаруй ажилтан албан хаагчид оролцож, аймгийн Онцгой байдлын газар, Сүхбаатар сум дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ-ийн албан хаагч, оюутнууд аюулгүй ажиллагааны үзүүлэх тоглолт зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг дэлгэрүүлэх зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг Аймгийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг энэ сарын 5-8-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү тэмцээн нь энэ жил 2 үе шаттайгаар зохион байгуулагдах болсноороо онцлогтой бөгөөд тэмцээний 1-р шат аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, төмөр зам, банк, хилийн цэргийн ангиудын ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулагдаж, тэмцээнд нийт 500 гаруй төрийн албан хаагчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, багийн нийлбэр дүнгээр Төмөр замын баг тэргүүллээ. Арга хэмжээний нээлтийн үеэр ажил спорт хоёрыг хослуулан олон жилийн хүч хөдөлмөрөө шингээж яваа спортын мастер зэрэг цолтой төрийн албан хаагчдад аймгийн Засаг даргаас хүндэтгэл үзүүллээ.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Хэмжилзүйн лабораторийн 1-р улирлын тайланг Стандарт хэмжилзүйн газрын хэмжилзүйн хүрээлэнд, хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээ, баталгаажуулалтын хоорондын хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг тус газраас ирүүлсэн чиглэлийн дагуу гаргаж хүргүүлсэн.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагын болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний тоолуурын баталгаажуулалт, ухаалаг тоолуураар төлбөр тооцоо хийх аргачлалын талаар мэдээ, мэдээлэл өгөх, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор “Дэлхийн хэмжилзүйн өдөр”-ийг угтан Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн өдрийг Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХХК, Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж, 100 гаруй гарын авлага материал тараан, 46 иргэнээс судалгаа авч санал хүсэлт, годлыг шийдвэрлэх арга хэмжээ авлаа.

Тайлант сард Сайхан, Сүхбаатар Алтанбулаг, Мандал, Хүдэр, Ерөө, Шаамар сөум, Бугант тосгоны 29 аж ахуйн нэгж, иргэний 15 хүнсний дэлгүүр, 3 минимаркет, 4 хүнсний мухлаг, 1 зоогийн газар, 1 зочид буудал, 1 үсчин, 1 караоке баар, 3 цайны газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон.

Сүхбаатар сумын 2 аж ахуйн нэгжийн 8 нэрийн 14 хүнсний бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтын хамруулж, стандартын салбар сангаас 8 аж ахуйн нэгж, байгууллага иргэний 10 нэрийн 12 стандартын захиалгыг авч, 8 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 11 нэрийн стандартаар борлуулалт хийж, 3 аж ахуйн нэгж, байгууллага иргэнийг 3 нэрийн стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн.

Мөн ээлжит баталгаажуулалтаар Хүдэр, Ерөө сумдад ажиллаж, худалдааны газруудын 80 жинг хамруулж, массын хэмжлийн төрлөөр сорилтын лабораторийн 2 электрон жинд шалгалт тохируулга хийлээ.

Цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын айл өрхийн 7 ширхэг нэг фазын электрон тоолуур баталгаажуулалт хийж, Хүдэр, Ерөө сум, Бугант тосгоны 5 шатахуун түгээх газрын 14 түгээгүүрийг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг сумд болон төсөвт байгууллагуудаас хүлээн авч, Сангийн яаманд хянуулж эхлээд байна. Мөн 2018 оны 1-р улиралд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг 2412 аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авахаас 2264 байгууллагын тайлан хүлээн авч тайлагналт 93,9 хувьтай, цалин хөлсний албан татварын тайланг 2646 аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авахаас 2464 аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авч 93,1 хувьтай, суутгагчийн хувь хүнд олгосон татварын тайланг 300 аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авахаас 300 аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авч 100,0 хувьтай, бусад татвар төлбөр хураамжийн тайлан хүлээн авалт 100,0 хувь тус тус хүлээн авч гүйцэтгэлийн стандарт ханган, холбогдох програмуудад боловсруулан ажиллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагууд, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаг байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд зэрэг 261 байгууллагыг хамруулан шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлтэд аудит хийхэд мэдээлэл байршуулалт 92,0 хувьтай байна.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	19.443.429.3	21.919.436.6	112.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	3.173.579.6	4.304.165.5	135.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2.285.781.9	3.037.114.1	132.9

	Сумдын төсвийн орлого	887.797.7	1.267.051.4	142.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2.000.000.0	2.000.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	12.248.723.2	12.248.723.2	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	654.512.4	467.267.4	71.4
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1.229.303.8	2.761.970.3	224.7
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	137.310.3	137.310.3	100.0
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		19.443.429.3	16.299.556.8	83.8
Орон нутгийн төсвийн нийт зарлага		19.443.429.3	16.299.556.8	83.8
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		2.737.514.2	2.083.506.5	66.8
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		418.282.9	25.900.3	-
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		4.014.077.3	2.816.020.1	70.2
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		330.000.0	94.200.0	28.5
Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт		80.000.0	-	-
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		335.251.0	-	-
Халамжийн сан		2.253.667.1	1.864.108.7	82.7
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		925.159.2	779.565.0	84.3
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		90.000.0	78.146.4	86.8
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		11.409.160.1	10.627.951.7	93.2
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		864.394.8	746.178.2	86.3
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		14.186.836.5	14.032.423.8	98.9
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1.283.055.6	1.283.055.6	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		364.729.1	248.355.6	68.1
Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд		32.832.3	32.832.3	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд		54.001.4	54.001.4	100.0
Хөрөнгө оруулалтын зардалд		277.895.4	161.521.9	58.1
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		290.328.6	252.289.4	100.0
Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд		289.783.3	251.744.1	86.9
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		545.3	545.3	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11.393.497.9	11.393.497.9	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	855.225.3	855.225.3	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		12.248.723.2	12.248.723.2	100.0
- Ерөнхий боловсролын сургууль		5.981.512.9	5.981.512.9	100.0
- Хүүхдийн цэцэрлэг		3.115.151.7	3.115.151.7	100.0
- Соёлын байгууллага		896.803.7	896.803.7	100.0
- Биеийн тамир спортын байгууллага		421.597.6	421.597.6	100.0
- Эрүүл мэндийн байгууллага		1.619.791.9	1.619.791.9	100.0
- Газрын кадастрын байгууллага		109.585.5	109.585.5	100.0
- Хүүхдийн байгууллага		104.279.9	104.279.9	100.0
4. Тусгай сангуудын зарлага		417.820.8	30.228.8	7.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 III- сар	2018 IV- сар	<u>2018- IV</u> <u>2018-III</u> <u>/төгрөгөөр/</u>
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	100.0
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	5 500	6000	109.1
Үхрийн мах /кг/	7000	7500	107.1
Адууны мах /кг/	5 000	5 500	110.0
Ямааны мах /кг/	4 800	5000	104.2
Дотор мах, цувдай /цусгүй/	3 500	3 500	100.0
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
Сүү /задгай, л/	1800	1500	83.3
Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
Тараг /задгай, л/	2000	1 800	90.0
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12 000	12 000	100.0
Айраг /л/	3 500	3 500	100.0
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
Өөхөн тос /кг/	1500	1 500	100.0
Шар тос /кг/	15000	15000	100.0
Масло /задгай, кг/	4500	4500	100.0
5 ХҮНСНИЙ НОГОО			
Төмс /кг/	1 200	1 200	100.0
Лууван /кг/	1 200	1 200	100.0
Манжин /кг/	1 500	1 500	100.0
Байцаа /кг/	1 500	1 500	100.0
Сонгино /кг/	1 500	1 500	100.0
Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3500	3 500	100.0
Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7 ШАТАХУУН			
Бензин А - 80	1 590	1 590	100.0
Бензин А - 92	1 735	1 735	100.0
Дизелийн түлш	2025	2020	99.8

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв хамтран 2018 оны 04 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд тус аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт

хуульчдад сургалт зохион байгуулж, иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өглөө.

“Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS 6264:2011 стандартыг шинэчлэн боловсруулах тухай хэлэлцүүлгийг 04 дүгээр сарын 16-нд зохион байгууллаа.

2018 оны эхний 05 дугаар сарын 01-ний байдлаар аймгийн хэмжээнд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 319, гэмт хэрэг 249 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гомдол мэдээлэл 26.5%-иар буурсан, гэмт хэрэг нь 13.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлангийн хугацаанд шинжээч эмч нар нь мөрдөгч, прокурорын тогтоолоор эрүүгийн гэмт хэрэгт шүүх эмнэлгийн нийт 295 шинжилгээ хийснээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг шинжилгээ 219 удаа хийсэн бөгөөд үүнээс 0-17 насны 17, 18 ба түүнээс дээш насны 133 хүнд гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, магадлан шинжилгээ 49 удаа, үүнээс 0-17 насны хүний амь нас хохирсон гэмт хэрэгт 5, 18 ба түүнээс дээш насны хүн нас барсан гэмт хэрэгт 44 удаа магадлан шинжилгээ хийсэн байна.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчлийн тухай” хууль, “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай” хууль, “Ахмад настны тухай” хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, “Хүүхэд хамгааллын тухай” хууль болон Мэргэжил сонголт, Бэлчээр хамгаалал, “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам” зэрэг сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлуудыг Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал, Хүдэр, Зүүнбүрэн, Жавхлан, Орхонтуул, Хушаат, Цагааннуур сумдуудад болон зохион байгуулж нийт 1546 иргэнийг хамрууллаа.

Архивын чиглэлээр:

Архивын тасагт АЕГ-аас мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсэг 4-р сарын 27-ны өдөр ажиллаж, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж буй ажлын явц, биелэлт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлтэй танилцаж цаашид авах арга хэмжээний талаар холбогдох заавар зөвлөгөө өгч ажилласан. Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар-108, цаасан суурьтай баримтнаас-52, мастер хувиас-141 магадалгаа, тодорхойлолт-154, цалингийн тодорхойлолт- 3-ыг тус тус гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

“Төрөлжсөн олимпиад зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу 9 дүгээр ангийн сурагчдын монгол хэл бичгийн аймгийн олимпиадыг 4 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж нийт 32 сургуулийн 32 бүлгийн 725 сурагч амжилттай оролцож Сүхбаатар сумын 4-р сургуулийн 9б бүлэг 28,58 дундаж оноогоор тэргүүн байранд шалгарсан.

2017-2018 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 2018 оны 03 дугаар сарын 23-31-ний өдөр зохион байгуулж олимпиадад 51 ангиллаар 928 сурагч, 434 сурагч оролцсон. Монгол улсын Засгийн газар болон Япон улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу Боловсрол, Соёл шинжлэх ухаан, Спортын яам нь 2014 оноос эхлэн “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг хэрэгжүүлж байна.

2018-2019 оны хичээлийн жилд Япон улсад 1000 инженер бэлтгэх “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд Коосэн сургалтын хөтөлбөр /Японы үндэсний технологийн коллеж/ болон бакалаврын сургалтын хамтарсан хөтөлбөрт

/Японы их дээд сургуулийн консорциум/-т хамрагдан цаашид инженер, технологийн чиглэлээр суралцах хүсэлтэй төгсөгчдөөс урьдчилсан сорил авах бүртгэлийг Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд явуулан аймгийн хэмжээнд нийт 114 хүүхэд бүртгүүлж төслийн багт нэрсийг хүргүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газар, Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга хамтран МУСТА Л.Баасанхүүгийн нэрэмжит өсвөрийн хөгжимчдийн аймгийн анхдугаар уралдааныг 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулж аймгийн 14 сумын 18 сургуулийн 140 гаруй сурагчид оролцсон. Чуулгын уран бүтээлчдийн “Хаврын уянга” тоглолтоо 2018 оны 04 дүгээр сарын 10-16-ны өдрүүдэд Жавхлант, Ерөө, Хүдэр сумд, Бугант тосгоноор Ерөнхий боловсролын сурагчдад уран бүтээлийн аялан тоглолт зохион байгуулж, 500 гаруй хүүхдүүд үзсэн. Цахилгаан хөгжмийн “Чавхдаст хөглөгдсөн 33 жил” шинэ уран бүтээлийн тоглолтоо 2018 оны 04 дүгээр сарын 12-нд Сэлэнгэ түмэндээ толилуулсан.

Тайлант сард хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн Усан спорт сургалтын төвөөс “Би сэлж сурсан” анхдугаар тэмцээнийг тус тус зохион байгуулснаас гадна Д.Сүхбаатарын нэрэмжит чөлөөт бөхийн 41 дэх удаагийн Олон Улсын тэмцээнийг зохион байгуулж, ОХУ-ын Буриад улсаас Хиагтын, Кижингийн 3 баг, 9 аймаг, 4 дүүрэг, клубуудын нийт 27 багийн 470 гаруй тамирчид охид хөвгүүдийн 20 жинд өрсөлдсөнөөс 58 оноогоор Дархан Хасу Тэргүүн байр, 39 оноогоор Улаанбаатар хотын Биеийн тамирын дунд сургууль, 38 оноогоор Женко клуб удаалсан.

2.Эрүүл мэндийн талаар:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албатай хамтран сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Сувилагч нарын сувилгааны түүх хөтлөх ур чадварыг сайжруулах” вакумжуулсан сургалтыг 17 сум, 6 тосгоны Эрүүл мэндийн төвийн нийт 24 ахлах сувилагчийг сургаж сургагч багшаар бэлтгэсэн.

Аймгийн Онцгой байдлын газартай хамтран зарлан мэдээллийн дохиогоор Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн нийт 182 ажиллагсад гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулж Эрүүл мэндийн газрын ажиллагсадын аранзыг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Дэлхийн эмч нарын өдөр, Олон улсын сувилагч нарын өдрийг “Сүүн мөртэй Сэлэнгийн эрүүл мэндийнхэн” уриатайгаар “Сүрьеэгүй Сэлэнгэ хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулж буй ажлын тайлан, сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, караоке, спортын 6 төрлөөр зохион байгуулж эрүүл мэндийн салбарын 6 багийн 150-д тамирчид оролцсон.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны 03-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 911 байсан бол 353 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 57 ажлын байранд 45 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 356 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 863 болсон байна.

Мандал, Зүүнбүрэн, Цагааннуур, Хушаат, Баруунбүрэн, Сант сумд, Номгон, Дулаанхаан, Рашаант тосгодын Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 791 сурагч, анги удирдсан багш, нийгмийн ажилтан нарыг хамруулан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Ирээдүйн эзэд” сургалтыг зохион байгууллаа. Мөн Зүүнхараа политехник коллежийн 137 суралцагчдад “Ажил хөдөлмөр амжилтын эхлэл” сургалтыг зохион байгуулсан. Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Шаамар, Хушаат, Сайхан, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Хүдэр, Ерөө, Бугант, Баянгол, Мандал сум Номгон, Дулаанхаан, Рашаант, Хэрх, Түнхэл тосгодын Хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийн ажлын байртай танилцах, сумдын Хөдөлмөр, халамжийн мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Сүхбаатар, Сайхан, Баруунбүрэн, Сант сум, Рашаант, Номгон тосгоны хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 408 өрхийн гишүүн, иргэдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлттэй хэрхэн уялдуулах талаар болон Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүн, цаашдын хэрэглээ сэдвээр сургалт зохион байгуулсан.

Нийгмийн халамжийн сангаас 04 сарын байдлаар 30,981 иргэнд 4,528,420.0 төгрөгийг олгоод байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 6 хүүхдийг хяналтандаа авч зан үйлийг өөрчлөх сургалтанд хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар 15 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхэмлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор гэрлэж буй хосуудад “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт мэдээллийг хийж, гэр бүлийн тангараг өргүүлэн, гэрлэлтийн баталгаа гардуулах ажлыг “Хүндэтгэлийн танхим”-д зохион байгуулж нийт 4 залуу хосод үйлчилгээ үзүүлсэн. Ахмад багш нарын зөвлөх багтай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эх, багш нарын дунд “Эрдэм шинжилгээний бага хурал” илтгэлийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулж нийт 34 сургуулийн давхардсан тоогоор 70 эцэг эх, багш нар хамрагдсан.

“Гэр бүл, хүүхэд хамгаалалд-эцэг эхийн оролцоо” аймгийн зөвлөгөөн зохион байгуулж аймгийн эцэг эхийн зөвлөлийг байгуулж хэлэлцүүлэг хийж ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг таниулан сурталчлах ажлын хүрээнд Залуучуудын хөгжлийн танхимаар үйлчлүүлсэн 90 орчим залууст сургалт мэдээллийг хийсэн. “Ирээдүйн эзэд” үндэсний мэргэжил сонголтын аяны хүрээнд “Мэргэжил бүхэн сайхан” ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Мини аялал”-ыг аймгийн “Эрүүл мэндийн газар”, “Цагдаагийн газар”, “Онцгой байдлын газар”, “Алтан тариа”- ХХК-тай хамтран Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 7 сургуулийн 10-12 дугаар ангийн 28 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Аяны хүрээнд аймгийн 17 сум, 6 тосгоны 34 сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?” сонин тараах материалыг хүргүүлсэн. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 11 дуудлагад хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж, 1 дуудлагад Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэхээр болсон. Дуудлагыг хүүхдийн хүчирхийллийн хэлбэрээр ангилбал: Үл хайхрах 3, сэтгэл санааны дарамт 3, бие махбодын хүчирхийлэл 2, нас барсан 1, алга болсон 1 байна.

Яруу найрагч Г.Сэр-Одын нэрэмжит “Дунгийн эгшиг” өсвөрийн яруу найрагчдын наадмыг зохион байгуулж наадамд 10 сум, 3 тосгоны 42 хүүхэд 6-9, 10-12 дугаар ангийн насны ангиллаар оролцож тэргүүн байр эзэлсэн 2 хүүхдийг “Хүрэл тулга” улсын уралдаанд оролцох эрхээр шагнасан.

“Үнсгэлжин-2018” хувцас загварын уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Үндэсний хувцас”, “Гоёлын хувцас”, “Уран сэтгэмж” гэсэн 3 төрлөөр зохион байгуулж уралдаанд 15 сургуулийн 46 өсвөрийн дизайнерууд, 120 загвар өмсөгчид оролцосон.

Өсвөр насны охидын эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүднээс “Хүчирхэг охид-Хүчирхэг улс” сэдэвт сургалтыг “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 120, 10-11 дүгээр ангийн 200, нийт 320 охидод зохион байгуулсан.

5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2018 оны 04 сарын 23-ны байдлаар 7,2 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 04 сарын 23-ны байдлаар өссөн дүнгээр 6,7 тэр бум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 92.96 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16069 тэтгэвэр авагчдад 15085.52 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 1560 хүнд 683.25 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 235 хүнд 298.41 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 109 хүнд 167.21 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2018 оны 04 сард нийт 3 хурал хийж 244 хүнээс, 13 хүнийг цуцалж, 33 хүн шинээр тогтоолгосон, 198 хүн актаа сунгуулсан байна. Нийгмийн даатгалын байцаагч нарын дотоод үйл ажллагааг шалган, туслах ажлын удирдамжийн дагуу Жавхлант, Хүдэр, Шаамар сум Бугант тосгонд ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрүүдэд 1, 3, 4, 5, 7, 8 дугаар багуудад нийгмийн даатгал, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, сумын Газрын мэргэжилтэнүүдтэй хамтран шинээр гарсан хууль тогтоомжийн талаар сургалт сурталчилгаа зохион байгууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Төрийн ордонд 4 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулагдсан “Тариаланчдын Улсын зөвлөгөөн”-д аймгийн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ эрхлэгчдийн 100 төлөөллийг оролцуулж, аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын төлөөлөл “Сүү” ХК, “Тэсо” ХХК-ний “Милко” үйлдвэр, “АПУ” ХК-ний “АПУ дэйри” компанийн сүү боловсруулах үйлдвэрүүдийн удирдлагуудтай уулзаж, цаашид хамтран ажиллахаар санал солилцлоо.

Бага оврын трактор, чацарганы суулгацын эргэн төлөлтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Тариалан эрхлэлтийг дэмжих сантай хамтран Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын аж ахуйн нэгж, иргэдтэй тооцоо нийлсэн акт үйлдэж, Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Хушаат сумдын 36 хоршоог Хоршоодыг үнэлэх үнэлгээнд хамруулсан.

Энэ онд нийт 724676 эх мал төллөхөөс 04 дугаар сарын 24-ны байдлаар нийт 337645 мал төллөж үүнээс ингэ 28, гүү 1902, үнээ 15854, эм хонь 186839, эм ямаа 133022 төллөөд байна.Төлийн хорогдол 2413 үүнээс унага 55, тугал 214, хурга 1014, ишиг 1130 хорогдсон дүн мэдээтэй мал төлөлт 47 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол нийт 6313 үүнээс тэмээ 2, адуу 389, үхэр 1510, хонь 2321 ямаа 2076 үүнээс хээлтэгч мал нийт 1775 үүнээс гүү 68, үнээ 547, хонь 685, ямаа 475 хорогдож өвчнөөр нийт 278 мал үүнээс адуу 22, үхэр 74, хонь 83, ямаа 99 хорогдсон дүн мэдээтэй байна.

2014 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зарлагдсан зөгий аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх төсөлд шалгарсан тус аймгийн 7 сумын 22 иргэнд олгогдсон зөгийн бүл авсан иргэдийн эргэн төлөгдөх хугацаа энэ оны 05 дугаар сарын сүүлээр хийгдэж эхлэхтэй холбогдуулан Мал хамгаалах сангийн мэргэжилтний хамт Шаамар, Сүхбаатар сумдад ажиллан иргэн төлөгдөх зөгийн бүлийг Сэлэнгэ аймгийн иргэд, зөгий аж ахуй эрхлэгч нарт дахин олгох ажлыг Мал хамгаалах санд саналаа хүргүүлээд байна.

Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран мэрэгч тодотгох сургалгааг Баянгол 5.0, Баруунбүрэн 6.0, Орхон 5.0, Сайхан, Сант 2.5, Орхонтуул 5.0, Мандал 4.0 га-д энгийн механик аргаар нийт 30 мян/га бэлчээрт тэмцэх арга хэмжээг зохион байгуулах зайлшгүй шаардлагатайг дүгнэлт гаргаж ХХААХҮЯ-нд хүрүүлээ.

“Мерси Кор” ОУБ-ын хэрэгжүүлж байгаа “Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд” хөтөлбөр нь зорилтот найман аймагт малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоортэжээлийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой аж ахуйн нэгжийн дунд төсөл зарласан аймгийн тэжээлийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс нийт 17 төсөл ирж төслүүдийг шалгаруулан

5 төслийг хүргүүлж Шаамар сумын “Ундрагч” ХХК, Хушаат сумын “Ар сэвд могойт” ХХК-нууд шалгарч тус бүр 20,0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамрууллаа.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Жавхлант, Хушаат, Баянгол, Мандал, Алтанбулаг сумдад газрын тухай хууль тогтоомжийг таниулан сурталчлах, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор сумдын ИТХ, ЗДТГ-ын мэргэжилтэн албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Мандал сумын нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга лифтны хэсгийн зураг төсөл, Цагааннуур сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төслийг баталгаажууллаа.

Тайлант сард Сүхбаатар сумын 114 иргэнд Алтанбулаг сумын 2 элс, номтын чиглэлд өмчилсөн газрын материалыг гардуулан өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлж, Монгол Улсын иргэн газар өмчлөх тухай хуулийн дагуу газар өмчлөх хүсэлт гаргасан 32 иргэний өргөдлийг хүлээн авч 29259 м2 буюу 93577500 төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжийн төсөл бэлдээд байна.

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд.

“Ойн үрийн генетик нөөцийн тухай” төслийн багтай хамтран “Үр түүх тухай” сургалтыг зохион байгуулж, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн 20 гаруй иргэд хамрагдаж, үр түүх талбайг сонгох, үрийн ургацын балл тогтоох тухай, үрийг тээвэрлэх, хадгалах тухай, мод сөөгний үрийн чанарын шинжилгээ хийх тухай зэрэг сэдвүүдээр танхимын сургалт хийлээ.

“Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл”-ийн 2018 оны төлөвлөгөөг сумдад хүргүүлж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд ойн сан гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүсэн.

Цагааннуур, Түшиг, Баруунбүрэн, Мандал, Хүдэр зэрэг сумдын Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн хугацаа нь дууссан ойн менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах чиглэлийг сумын болон сум дундын Ойн анги, тухайн сумыг хариуцсан байгаль хамгаалагч нарт өгч, хяналт тавьж ажиллалаа.

Ерөө сумын нутагт орших Толгойтын алтны уурхай болох “Ди Зэт энд Ай” ХХК-ийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, өмнөх оны нөхөн сэргээлтийн ажлыг хүлээлгэж өгсөн акт, ус ашиглуулах дүгнэлт, гэрээ зэрэг бичиг баримтын бүрдэлтийг шалгаж 2018 онд ажиллах тойрох хуудсыг өгсөн.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Жавхлант сумын шарын голын гүүрний орчимд цагдаагийн газартай хамтарч 45 хоногийн хугацаанд хяналтын пост ажиллуулж байна.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

Сумын 3-р багт ХАА-н тасаг, багийн Засаг дарга нар энэ сарын 16-17-ны өдрүүдэд ажиллаж, 76 өрхөөр орж, мал амьтны гоц халдварт өвчний талаар мэдээлэл өгч, төл бойжилт, хорогдлын мэдээ авч, 5-р сарын 1-ний өдөр соёл мэдээллийн төвд зохион байгуулагдах Малын эрүүл мэндийн сургалтын зарыг хүргэж, урилга тараасан. Мөн ХХААХҮЯ-аас явуулсан туслах малчны талаарх 30 ширхэг санал асуулгыг малчдаас авч, “Хөх сав, канистергүй баг, сум хөдөлгөөн”-ний ажлын төлөвлөгөөний дагуу хөх сав, канистер хэрэглэдэг өрх, айлын судалгааг авч, хуванцар савны хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан.

Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх эргүүл шалгалтыг нийт 10 удаа зохион байгуулж, сумын Засаг даргын захирамжаар “Бүх нийтийн хог цэвэрлэгээ”-г зохион байгуулж, төр төсвийн байгууллагуудын ажилтнууд нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэж, айл өрхүүд хашаа, гудамжаа цэвэрлэж, хогийг хогийн цэгт тээвэрлэн хаясан. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хяраан, Оргидог, Буриад хонди, Худаг өндөр, Хонд, Ивцэг, 2 элс, Хөдөө нуур, Согообулаг чиглэлийн малчдад санамж бичиг, гарын авлагыг тарааж, гурвалсан гэрээ байгууллаа.

REDD+ төслийн хүрээнд Ойн нэмүү өртгийг шингээх сүлжээний судалгааны төслийн олон улсын зохицуулагч Reinhold Glauner, Үндэсний зөвлөх доктор Д.Дэлгэржаргал нар “Ногоон нарс” ХХК-ийн паниарны үйлдвэр, “Хишиг-Өндөр ой” БГБХН-ийн 2017онд хийсэн тохируулах огтлолын талбайг үзэж, ойд унасан хаягдал унианги, хожуулаар юу хийж болох талаар судалгаа хийсэн.

Олон Улсын сувилагчийн баярт зориулсан “Сувилахуйн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгч үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалъя” уриан дор зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гаргаж нээлтийг хийж, үйлчлүүлэгчийн үндсэн эрхийг хамгаалах чиглэлээр байгууллагаа үнэлж дүгнэх тусгай саналыг авч, үйлчлүүдэгчээс санал авах ажлыг давхар зохион байгуулсан. Мөн эрүүл мэндийн байгууллагад амжилттай ажиллаж байгаад гавъяаныхаа амралтанд байгаа ахмад сувилагч К.Оюунбатын хөдөлмөр алдрыг тэмдэглэх “Дурсамж цэнгүүн”-ийг 04 сарын 07-нд сумын соёл мэдээллийн төвд зохион байгуулж, ЭМТ-ийн хамт олон, гэр бүл, найз нөхдүүд оролцож гарын бэлэг гардуулсан.

Сумын хэмжээнд шинээр төрсөн хүүхдийн тоо 6, эцэг тогтоолт 2, нас барсан хүний тоо 3, шилжин явсан иргэдийн тоо 13, шилжин ирсэн иргэдийн тоо 9, иргэний үнэмлэх шинээр буюу сунгуулсан иргэдийн тоо 18, Монгол-Оросын улсын хилийг нэвтрэх бичиг 2353, эд хөрөнгийн эрхийн бүртгэлд 6 байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн гишүүн иргэдэд мэдээлэл олгох сургалтыг 4 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулж, өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг “хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ авсан иргэний анкет”-д нийт 56 иргэнийг бүртгэж ажиллалаа. Тайлант сард зорилтод бүлгийн 59 өрхийн 374 иргэнд 1, 2 дугаар сарын хүнсний эрхийн бичгийг олгож 8,680,000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Хүүхэд 1 бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаа өдрийн дэглэмийн дагуу явагдаж байна. Бид хүүхдийн суралцах үйлийг өдөөсөн, сонголттой баялаг орчин бүрдүүлэн ажиллаж байна. Хүн болох багаасаа хөтөлбөрийн хүрээнд дунд бүлэг долоодой, ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүд могой шоо, рубик шоогоор хичээллэж байна. Мөн бүлгүүд хүүхдүүдээ эрүүл агаарт гарган чийрэгжүүлж, бэлтгэл бүлгийн хүүхдүүд, багш, эцэг эхчүүд малчны хотхоноор зочилж, нэгэн өдрийн үйл ажиллагааг хамтдаа өнгөрүүлээ.

Баруунбүрэн сум:

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт мал төллөлт, малын зүй бус хорогдлын мэдээг сар бүр өгч байгаа ба 4-р сарын 25-ны байдлаар сумын хэмжээнд нийт 710 толгой мал хорогдсноос адуу-75, үхэр-155, хонь-220, ямаа-26 толгой, төл бойжилт нийт 54818 толгой хээлтэгч төллөснөөс гүү 250, үнээ 510, хонь 32397, ямаа 21661 толгой байна. Төлийн хорогдол нийт 915 толгой байгаагаас унага 45, тугал 76, ишиг 414, хурга 380 хорогдсон. Малыг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага материал бэлтгэн малчид, аж ахуйн нэгжүүдэд тарааж, зөвлөмж өглөө. Орхон аймгийн Жаргалант сумын харъяат иргэн Х.Тулгын хотноос тус сумын 3 дугаар багт 3 үхэр ачиж ирснийг холбогдох газарт нь уламжлан буцааж, тухайн хашаанд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн. Сумын хэмжээнд 9550 га талбайд чийг хаалтын боловсруулалт хийж, 3 аж ахуй нэгж 3000 гаруй га талбайд огтоно устгалын ажлыг хийлээ.

2018 онд Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрт гаргах 2 худгийн байршлыг тогтоон мэргэжлийн байгууллагаар усны нөөцийг тогтоолгох ажлыг хийлгэлээ.

Эзэнгүй золбин нохойг устгах “Устгагч бүлэг” болон багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нартай хамтран 48 нохойг устган зохих заавар журмын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Аймаг, сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж, хаврын хуурайшилтын үед орон нутагт ажиллах “Морьт эргүүл”-ийг томилон хамтран ажиллаж, захирамжийг олон нийтэд танилцуулах, болзошгүй галын болон ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна. Хил залгаа Булган аймгийн Хангал, Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГазар, БОХ-ын Улсын байцаагч нартай ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үед хамтран ажиллах тухай гэрээг байгуулан ажиллаж, түймрийн багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, шинэчлэх ажлын хүрээнд төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж бүрийн ажилчин нэг бүрээр түймрийн багаж хийлгэх, хүлээн авах ажлыг зохион байгуулаад байна.

Хоггүй сум аяны хүрээнд 7 хоногийн Баасан гараг бүрт бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд нийтийн цэвэрлэгээнд хамрагдаж өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны харъяа Ойн Судалгаа Хөгжлийн Төв УТҮГ, UN-REDD үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэгийн хамтран зохион байгуулсан “Ойн суурь түвшний мэдээг боловсруулах, чадавхийг бэхжүүлэх” сэдэвт сургалтанд сумын байгаль хамгаалагчийг хамруулсан.

Төрийн санд 2018 оны 04 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 49287.8 төгрөг орохоос гүйцэтгэлээр 14073.2 мянган төгрөг орж биелэлт 28.6%-ийн биелэлттэй, туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 9800.0 мянган төгрөг орохоос гүйцэтгэл нь 6504.4 мянган төгрөг орж биелэлт 66.4%-тай байна. 2017 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Сумын сургуулийн зорилгод тусгагдсан ажлын хүрээнд 1-12 дугаар ангийн сурагчдын дунд Эх нутаг, сургуулиараа бахархах зорилгоор “Сэтгэлийн эгшиг” уран уншлагын уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, нийт 600 гаруй сурагч, багш, эцэг эхчүүд хамрагдаж, шилдгүүдийг шалгаруулан цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Сумын Засаг даргын захирамжаар “Урлаг-Спорт 2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд шатар, гарбөмбөгийн тэмцээнийг зохион явуулсан. Мөн Баруунбүрэн сумын ИТХ-аас зохион явуулсан Орхон бүсийн “Гар бөмбөгийн өсвөрийн аварга шалгаруулах” тэмцээнд 8 сургуулийн нийт 80 тамирчин сурагчид оролцож тус сумын эрэгтэй баг 3-р байр, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнуулж тус тэмцээний “Шилдэг холбогч”-оор 12а ангийн сурагч Э.Ганбат шалгарсан байна.

“Хүүхдийн төлөө хамтдаа” чуулганыг зохион явуулахад 4-12 дугаар ангийн 120 эцэг эх, сурагч, багш нар оролцож, ахмад багш Н.Мөнхтэгш, П.Бямбасүрэн тэргүүн туршлагаасаа хуваалцлаа.

Баянгол сум:

Олон Улсын хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын аяны хүрээнд “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлцгээе” уриан дор нээлтийн ажиллагааг 4-р сарын 4-ний сумын ХАБА салбар зөвлөл, сумын ҮЭХ, ажил олгогч эздийн холбоод хамтран өдөр зохион байгуулж, төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн 118 албан хаагч оролцож, сумын ЭМТ, Гал унтраах аврах 40-р ангийн албан хаагчид үзүүлэх сургалт хийж, “Тод ундрага” ХХК-д зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хамарсан бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 268 хүн хамрагдсан. Сумын төвийн хэсгийн тохижилтыг хийж 30 гаруй модыг тайрч цэвэрлэсэн.

Сумын хэмжээнд 4-р сарын 23-ны байдлаар мал төллөлт 48,7 хувьтай байна. Үүнд: Гүү 112, үнээ 519, эм хонь 19948, эм ямаа 11783, нийт 32362 толгой эх мал төллөж, төлийн бойжилт 99,5 хувьтай, том малын зүй бусын хорогдол 619, төлийн хорогдол 140 байна. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын захирамж гарч, замын шалган нэвтрүүлэх пост дээр 1260 тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийж, сэрэмжлүүлэг мэдээллийг Баруунхараагийн зарын нэгдсэн групп болон facebook хуусанд байршуулж, МЭҮН-үүд хамтран 3 багийн 120 гаруй малчин, мал бүхий айл өрхүүдэд ажилласан.

Аймгийн МХГ-аас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг эргүүл шалгалтыг хийж, Буянт гэх газарт алт олборлох зорилгоор гар аргаар газрын хэвлий ухаж байсан хэсэг бүлэг иргэдийг тараасан.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлдэх сэрэмжлүүлэх хуудсыг тарааж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг тооллыг хийсэн.

Тайлант сард шинээр төрсөн 8, гэр бүл болсон 1, эцэг тогтоолтын бүртгэл 4, үржлүүлсэн, нас барсан 2, иргэний үнэмлэх шинээр 10, дахин 4, сунгалт 24, шилжин ирсэн 15, шилжин явсан 17 бүртгэлийг хийж, мэдээллийн санд оруулан баталгаажуулсан. Мөн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ 2, газрын гэрчилгээг 14 иргэнд олголоо.

Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож, нийтийн даатгалын шимтгэлд 45,0 сая төгрөгийн орлогыг оруулсан.

Ерөө сум:

Монгол улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”, Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын “Соёлтой харилцаа шуурхай-үйлчилгээ хөдөлгөөн өрнүүлж үр дүнг тооцох тухай” захирамж, сумын “Сахилга хариуцлагыг дээшлүүлж, шуурхай үйлчилгээг нэвтрүүлэе” жилийн ажлыг зохион байгуулах тухай захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Төрийн албан хаагчдын сахилга-хариуцлага” зөвлөгөөнийг 3 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд сумын ЗДТГ-ын 30, ЕБС-ын 33, Соёлын төвийн 6, ЭМТ-ийн 13, “Нарлаг” цэцэрлэгийн 23 албан хаагч, Бугант тосгоны захирагч болон төсвийн байгууллагын эрхлэгчид нийлсэн 7 албан хаагч нийт 112 албан хаагчид оролцож, “Хариуцлагын талаарх ойлголт, түүний төрөл хэлбэр” сумын Засаг даргын Тамгын газрын дарга илтгэл тавьж, “Манлайлал иргэдийн оролцоо” сэдвээр сургагч багш лекц уншиж, “Нэг иргэн-Нэг бүртгэл” сэдвээр сумын Иргэний бүртгэлийн ажилтан мэдээлэл хийж, төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар болон төрийн албан хаагчдад үүрэг чиглэл өглөө.

Энэ сарын 9-ны өдөр сумын соёлын төвд Тавин багийн Иргэдийн нийтийн хурал болж, 4 иргэн өрсөлдөж 52,9 хувийн саналаар нэр дэвшигч Б.Батбаатарыг томилуулахаар сумын Засаг даргад саналыг уламжлаад байна.

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн сарын аян-2018” арга хэмжээний нээлтийг 4-р сарын 03-ний өдөр зохион байгуулж, төр, төсвийн албан хаагчид болон бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүдийн төлөөлөл нийт 51 хүн оролцож, эрүүл мэндийн төвийн дарга яаралтай тусламжын тоног төхөөрөмж, ЗДТГ-ын дарга Гамшгаас хамгаалах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг тус тус танилцууллаа.

Сумын Засаг даргын 91 тоот захирамжийн дагуу хавар, намрын улиралд тогтмол зохион байгуулдаг хог цэвэрлэгээний ажлыг энэ сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд “Цэвэр орчин бидний амьдрал” уриатайгаар зохион байгуулан ажиллаж байна. Залуучуудын клубын залуус хамтран

төвийн арын засмал замаас орж ирсэн зам талбай, трактортой уул, төв зам дагуух хайсны хог хаягдлыг цэвэрлэж нийт 1 портер хог хаягдлыг хогийн цэгд хүргэлээ. Мөн Буурагчин 2-р багийн Ангархай аманд байрлалтай сумын нэгдсэн хогийн цэгийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж, цэвэрлэгээг нийт 70-аад иргэн идэвхитэй оролцлоо.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого 4 -р сарын 23-ны байдлаар 219103.0 мянган төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 110,6%- ийн биелэлттэй байна.

Ерөө сумын хэмжээнд 2018 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 14, орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8, эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 2 нийт 24 бараа, үйлчилгээг TENDER.GOV.MN хаягаар зарласан.

Ерөө суманд суурилагдсан ТҮЦ машинаар иргэд идэвхитэй үйлчлүүлж, бүсийн сумдын иргэд үйлчилгээ авах боломж бүрдсэн бөгөөд 3-р сарын 26-аас 4-р сарын 25-нийг хүртэл хугацаанд нийт 158 иргэн үйлчилгээ авсан байна.

Төвийн бүсийн аймгуудын ЕБС-ийн сурагчдын дунд зохиогдсон “ХАВРЫН ГОЁЛ 2018” уралдаан Ерөө суманд 2018 оны 04-р сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 4 аймгийн 19 багш, 160 сурагч хамрагдан оролцлоо.Тэмцээнийг сумын ЗДТГ, ЕБС, “ДООЛТ” ХХК, “Бэрлэг майнинг” ХХК, “Ганбаттулга” ХХК ивээн тэтгэсэн. Уралдааныг үндэсний хувцас, өдөр тутмын, гоёлын хувцас, уран сэтгэмжийн загвар гэсэн 4 төрлөөр, шилдэг загвар өмсөгч эрэгтэй эмэгтэй, өсөх ирээдүйтэй загвар өмсөгч, шилдгийн шилдэг загвар зохион бүтээгч, шилдэг багш, шилдэг сургууль гэсэн ангиллаар шалгаруулалт явагдаж үндэсний хувцасны загвараар тэргүүн байрыг Хушаат сумын 12-р ангийн сурагч Х.Саруулын “Дэлхийн гайхамшиг”, өдөр тутмын загварын төрөлд тэргүүн байрыг Орхон аймгийн 13-р сургуулийн 12е ангийн сурагч Ц.Хонгорзулын “Эрээн тахь”, гоёлын хувцасны төрөлд тэргүүн байрыг Мандал сумын 1-р сургуулийн 11а ангийн сурагч М.Отгонтуулын “Давалгаа”, уран сэтгэмжийн төрөлд тэргүүн байрыг Мандал сумын 1-р сургуулийн 11а ангийн сурагч М.Отгонтуулын “Усны луу” загвар тус тус түрүүлээ.

Сумын хэмжээнд нийт төллөх эх малын 18288 толгой нь төллөж, 56,1 хувьтай байна. 2018 онд тариалалт хийх талбайн судалгааг гаргаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Тайлант сард аймгийн АДБ-ийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын аялан тоглолт, УИХ гишүүн сайд Жаргалтулгын Эрдэнэбатын нэрэмжит шатар, дардас, воллейбол, ширээний теннис, даам зэрэг 5 төрөлт тэмцээн тус тус боллоо. Мөн энэ сарын 20-нд “Аяа миний Буриад зон олон” МНВ Монголын үндэсний телевизээр Ерөө сумын Буриад иргэд, сум сурталчлах урлаг, уран сайхны зураг авалт хийгдэж, дуу, бүжиг, хөгжим урлагийн арга хэмжээнүүд сумын Соёлын төвд хийгдлээ.

Жавхлант сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2, шуурхай хурал 4, албан хаагчдын хурал 1 удаа хуралдлаа. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус хуралдаан хуралдаж 16 төлөөлөгч оролцож, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай, сумын эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нэмэлт оруулах, сумын жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай болон сумын халаалтын нэгдсэн төвийг шугам цэвэр усны сүлжээний хамт барих ажлыг өөрийн хөрөнгөөр /концесс/-оор барих хүсэлт гаргасан “ММС Трейд” ХХК-ний саналыг дэмжин хамтран ажиллах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийг 4-р сарын 20-ны өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” уриан дор зохион байгуулж сумын Засаг даргын Тамгын газар, сургууль, эрүүл мэндийн төв, 26-р цэцэрлэг, соёлын төв, “Монжим-трейд” ХХКомпани зэрэг аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож яаралтай тусламжийг яаж үзүүлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх зэрэг үзүүлэх сургуулийг хийлээ.

Сумын ахмадын хорооноос хамтын ажиллагаатай Дархан-Уул аймгийн Дархан сумын 11-р багийн ахмадын зөвлөл, сумын ахмад ардын авьяастнуудын оролцсон "Ахмадын дуулал" тоглолтыг сумын иргэдэд толилуулсан.

Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа "Эрүүл насжилтын төлөө хамтдаа 2018-2020" аяны сургалтыг Герентологийн үндэсний төвийн их эмч доктор н.Дулмаа зохион байгуулж, зөвлөгөөний үеэр залуу гэр бүлийн "Андгай өргөх" ёслолын арга хэмжээ болж тус сумын залуу гэр бүлүүд андгай өргөлөө. Мөн зөвлөгөөнөөр "Ном бол ертөнцийг харах цонх мөн" номын хурим, "Яг түүн шиг" шоу, хийн дасгалын үзүүлбэр, софт волейболын нөхөрсөг уулзалт зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж, байнгын асаргаатай 4 ахмадад хүндэтгэл үзүүллээ.

Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх аймгийн хөтөлбөрийн хүрээнд 18-25 насны залуучуудыг эрүүлжүүлэх зорилгоор үзлэг, шинжилгээг хийлээ.Цусны ерөнхий шинжилгээнд 31, шээсний ерөнхий шинжилгээнд 29, цусны бүлэг тодорхойлох 28, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 34, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 34, цагаан хорхой илрүүлэх шинжилгээнд 3, элэгний С вирус илрүүлэх шинжилгээнд 22 хүнийг хамруулж, өөрчлөлттэй илэрсэн 13 хүнийг эмчлэн эрүүлжүүлж, онош баталгаажуулахаар дээд шатны эмнэлэгт 3 хүнийг илгээлээ.

Хөгжмийн зохиолч, МУСТА Л.Баасанхүүгийн нэрэмжит "Сэлэнгээр жигүүрлэсэн бидний эгшиг-2018" өсвөрийн үндэсний хөгжимчдийн анхдугаар уралдаанд Соёлын төвийн Хөгжмийн багш Б.Баттулгын удирдсан морин хуурын "Эгшиглэн" чуулга нь амжилттай оролцсон. Аймгийн Нийтийн номын сангийн арга зүйн танхимаас Жавхлант сумын номын санг Ерөө бүсийн "Бүс нутгийн загвар номын сан" болгох үйл ажиллагааны хүрээнддадлага туршлага солилцох сургалт зохион байгуулагдаж "Загвар номын сан" батламж гардан авлаа.

Улсын "Сэтгэх чадвар"-ын XVI олимпиадын 2-н даваанд 12 ангийн сурагч Б.Жаргалмаа 2-р байр, газарзүйн олимпиадаас 12а ангийн сурагч Б.Жаргалмаа 4-р байр, математикийн олимпиадаас 9а ангийн сурагч Г.Оюун 8-р байр, 7а ангийн сурагч Г.Сэржбүдээ 9-р байр, 10а ангийн сурагч Б.Мөнхжавхлан 8-р байр, 8а ангийн сурагч Б. Учрал 7-р байр тус тус эзэлсэн амжилтуудыг гаргалаа.

Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сумын Засаг даргын А/45 тоот "Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай" захирамжийн дагуу ханш нээж буйтай холбоотой хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх үед Шарын голын 3 замын уулзварт Сүхбаатар чиглэлд орох тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийгдлээ.

Сумын ногоочдын зөвлөгөөнийг зохион байгуулж Засгийн газраас газар тариалангийн салбарт үзүүлэх хөнгөлөлт, бодлогын дэмжлэг, "Жимс жимсгэнэ", "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөр,УГТЭШХүрээлэнгийн эрдэмтэн Н.Алтантуяа төмс хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтанд баримтлах технологийн ерөнхий зөвлөмж, хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх нарийн ногоо тариалалт ач холбогдол, газрын даамал газар өмчлөлт, хүнсний ногооны газар ашиглалт сэдвээр сургалт зохион байгуулж нийт 45 ногоочид хамрагдлаа.

Иргэдийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх зорилгоор сургалтуудыг зохион байгуулж байна. Тайлант сард "Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх" сургалтыг 2 удаа зохион байгуулж яаралтай эмнэлэгийн тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх сургалтыг гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний дунд гамшгийн болон болзошгүй эрсдлийн үед үзүүлэх анхны тусламжийг хүн бүр үзүүлэх чадвартай болгох онол, дадлага хосолсон сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчдын дунд зохион байгууллаа. "Гэгээн үйлс гэрэлт ирээдүй" ТББ-ийн тэргүүн Ц.Рэгзэдмаагийн санаачлагаар "Туслая, Дэмжье, хамтрая", "Ургах цаг" нийгэмлэгийн тэргүүн Ц.Даваадорж "Өрхийн эдийн засгийг хэрхэн хөтлөх вэ" сургалтыг тус тус зохион байгуулж нийт 29 иргэн хамрагдлаа. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд эрүүл мэндийн тухай хууль, халамжийн тухай хуулиар сургалт, Дархан –Уул аймгийн УГТЭШХ-ийн эрдэмтэн Н.Алтантуяа төмс хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтанд баримтлах технологийн ерөнхий зөвлөмж, хүнсний ногооны нэр

төрлийг нэмэгдүүлэх нарийн ногоо тариалалт ач холбогдол, газрын даамал газар өмчлөлт, хүнсний ногооны газар ашиглалт сэдвээр сургалт, аймгийн Хаан банк, төрийн банкнаас төмс хүнсний ногооны зээл олголт, зээлийн хүүгийн талаар иргэдэд мэдээлэл хийж, нийт 45 ногоочид хамрагдлаа.

Зүүнбүрэн сүм:

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд “Арвин хур”, “Гэгээлэг трейд”, “Одон буудай”, “Шижир болор”, Тэгш”хан” зэрэг аж ахуйн нэгжүүд 8849 га талбайд мэрэгч амьтан устгалын ажлыг хийлээ. Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шилжилт хөдөлгөөнийг хориглосон талаар малчдад мэлээлэл өгсөн.

Сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж, 14-р цэцэрлэгт “Бодлын хишиг” ХХК, ЕБС-д “Марат” ХХК тус тус хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарлаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тайлант сард төлөвлөгөөгөөр 2875 хүүхэд хамруулахаас 3046 хүүхэд хамрагдаж, ирц 103 хувьтай байна.

Тайлант сард сумын соёлын төвд сар бүр явуулдаг “Дуулах өдөр-дуун цэнгүүн” арга хэмжээг зохион байгуулснаас гадна “Хойморь нутгийн хийморлог Бүрэнчүүд” байгууллага сурталчлах өдөрлөг, урлагийн наадмыг зохион байгуулж, ЕББДС, 2, 3-р багийн иргэдийн урлагийн тоглолт болж давхардсан тоогоор 450 гаруй иргэнд үйлчилсэн.

4-р сард шинэ төрсөн 6, эцэг тогтоолт 1, нас баралт 2, иргэний үнэмлэх олголт 25, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 10, шилжин ирсэн 14, шилжин явсан 10, нийт 68 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

Мандал сүм:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Иргэний танхимд” 9-н багийн Засаг дарга, хэсгийн ахлагч нарыг оролцуусан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд-Иргэн бүрийн оролцоо” зөвлөлгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд сумын Прокурорын газар, Цагдаагийн хэлтсийн холбогдох хүмүүс оролцож, иргэдийн санал, хүсэлтийг сонсож, “Нэг гэрэл гудамжийг гэрэлтүүлэхгүй, тиймээс бүгдээрэй хамтдаа гэрлээ асаацгаая”, “Аюулгүй амар тайван амьдралд иргэн бидний оролцоо чухал” уриалга гаргасан.

Сумын Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг сурталчилах, тэдэнд мэргэжлийн байгууллагын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор 04 дүгээр сарын 20-ны өдөр худалдааны гудамжинд “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 22 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, 3 иргэний галт зэвсгийг бүртгэн, 5 хүнд галт зэвсгийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө өгч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, хугацаа нь дууссан 6 иргэнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхний талаарх лавлагаа олгож, жолооны үнэмлэхээ үрэгдүүлсэн, гэмтээсэн 10 иргэний материалыг хүлээн авч, 250 иргэнд “Хүчирхийлэлгүй хүүхэд”, “Зодуургүй гэр бүл”, “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хүүхдийн тусламж 108”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Зам тээврийн осол гэмтэл” зэрэг санамж, сэрэмжлүүлэг тараан өгч ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дэлхийн өдрийг угтан орон даяар жил бүр зохион байгуулагддаг “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н сарын аяны нээлтийг Соёмбот талбайд хийж, “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэе” уриан дор аж ахуйн нэгж, байгууллагуудад аялуулах цүнхтэй аяныг Зүүнхараа ПТК-аас эхлүүлсэн.

Мал өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар тус суманд хуваарилагдсан 30 тн өвсийг Дархан –Уул аймгийн улсын нөөцийн салбараас тээвэрлэн авчирч 9 багт малын тоонд харгалзан хуваарилан олгосон.

Мал төллөлтийн мэдээгээр 48726 эх мал төллөхөөс 15434 эх мал төллөж, 15437 төл гарч. Төл бойжилт 99,2 хувьтай байна. Том малын зүй бус хорогдлын мэдээгээр 483 мал хорогдсон.

“Газар тариалангийн тогтвортой хөгжил-2018” тариаланчдын улсын зөвлөгөөнд үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл 5, төмс, хүнсний ногооны аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл 2 иргэн, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Болормаа нар оролцов. Тус зөвлөгөөний үеэр тавигдсан мэдээллүүд болох Төрөөс газар тариалангийн салбарт баримталж буй бодлого чиглэл, 2018 оны 4-7 дугаар сарын цаг агаарын мэдээ, хаврын тариалалтанд баримтлах технологийн зөвлөмж, 2018 онд ХХААХҮЯ-наас импортоор оруулж ирэх техникийн жагсаалт-үнэ, тариалалтанд олгогдох үрийн улаан буудай, шатахуун, бордоо, пестицидийн талаарх мэдээллийг суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 17 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдээлж гарын авлагаар хангалаа.

2018 оны хаврын тариалалтанд шаардлагатай ургамал хамгааллын бодис, бордооны захиалгыг тариалан эрхлэгчдээс авч аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Жил бүр уламжлал болгон өрхийн тариалан эрхлэгч бүлэг, хоршоод ногоочдын дунд зохион байгуулдаг “Хаврын баяр-Хамтын хүч” буухиа, гар бөмбөгийн тэмцээнд 10 баг тамирчид амжилттай оролцлоо.

Сумын хэмжээнд 2018 оны “Тээврийн хэрэгслийн /автомашин, өөрөө явагч механизм, мотоцикл, чиргүүл/-ийн техникийн хяналтын улсын үзлэгийг 04 дүгээр сарын 02-ний өдрөөс 04 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Мандал сумын Засаг даргын захирамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж, нийт 30 машин 2400 шуудай буюу 120 тн хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт зөөж тээвэрлэсэн байна. Хог цэвэрлэгээний ажилд сумын хэмжээнд нийт 2700 гаруй айл өрх хамрагдлаа.

Мөн халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвд, сумын төвийн ойр орчимд хаясан хорогдсон нийт 1 тооны адуу, 44 толгой үхрийн сэг зэмийг лотер буюу авто ачигч болон 20 тн-ын даацтай хово буюу өөрөө буулгагч автомашинуудыг ашиглан зөөж тээвэрлэн хогийн нэгдсэн цэгийн тусгай цэгт хаяж устгалаа.

Мандал сумын Засаг даргын 2018 оны 03-р сарын 29-ны өдрийн 78 тоот " Ойн хээрийн түймрийн урьдчилан сэргийлэх тухай захирамж гарсаны дагуу багууд, банк, ЕБС, цэцэрлэгүүд, ОСГЭ ААНБ, нөхөрлөлүүд болон нийт 96 аж ахуйн нэгж, байгууллагад захирамжийг хүргүүлж, хуурайшилтын онцгой үед ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган ажиллуулж байна.

Ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаарх мэдээлэл өгөх, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор 4-р сарын 20-ны өдрийн “Мөнгөн Хараа” Дуу Бүжгийн чуулгад ЕБ-ын 6 сургуулийн 10-12 дугаар ангийн 600-аад сурагчдын дунд “Мэргэжил сонголт- экспо” өдөрлөгийг амжилттай зохион байгуулж “Өөрчлөлт шинэчлэлтийг өөрөөсөө” ТББ-ын тэргүүн С.Даваасамбуу болон Шинэ анагаах ухааны их сургууль, Урлах эрдэс дээд сургууль, Сэтгүүлч дээд сургууль, Тэнгэр дээд сургууль, Гурван эрдэм багшийн дээд сургууль, Батлан хамгаалах их сургууль, ШУТИС, Их засаг Олон улсын их сургууль, Томскын Их Сургууль гэх мэт 12 их дээд сургуулийн төлөөллүүд оролцож, өөрийн сургуулийн үйл ажиллагааболон онцлогийн талаар танилцуулга хийж, хүүхдүүдтэй уулзан ярилцаж, тараах материал, боршур тараан элсэн суралцахыг урилаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, ХБИ-ийн салбар зөвлөлөөс "Хамтдаа хөгжье" хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын олон төрөлт тэмцээнийг хамтран зохион байгууллаа. Сагсан бөмбөг, суугаа воллейбол, ширээний теннис,

шатар, даам, аха тэмцээн, зээрэнцэг зэрэг тэмцээнд 5 багийн 50 гаруй иргэд оролцож, багийн нийт дүнгээр Хэрх 4-р баг тэргүүн байранд шалгарлаа.

Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 6 кейс дээр үйлчилгээ үзүүлж аймгийн ГБХЗХГ-т үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргүүлсэн.

Орхон сум:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоолын дагуу газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажлын хүрээнд 2018 оны 3-р сарын 28-ны өдөр төр төсвийн байгууллагын төрийн албан хаагч, иргэдэд газар хөдлөлтийн гамшгийн аюул, газар хөдлөлтийн хор уршиг, гамшгийн үед хэрхэн ажиллах талаарх танхимын сургалтыг зохион байгуулж, газар хөдлөлтийн талаарх видео хичээлийг үзүүллээ.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 16.00 цагт төр төсвийн бүх байгууллагууд байгууллага тус бүр дээрээ зохион байгуулж дадлага сургуулилтыг хийж гүйцэтгэж 125 иргэн хамрагдсан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг батлуулж, аяны нээлтийг ирэдэд хууль тогтоомжийг сурталчлахаас гадна төр төсвийн байгууллагуудын уурын зуухны ажилчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангуулах зорилготойгоор зохион байгууллаа. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 5 төр төсвийн байгууллагуудын уурын зуухны өрөө тасалгаа, галч нарын ажиллах нөхцөл, галын аюулгүй байдал, зориулалтын хувцас хэрэгсэл, байгууллагын цахилгааны аюулгүй байдал зэрэг 6 асуудлаар зөвлөн туслах шалгалтыг зохион байгуулж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2017 оны А/01 захирамжаар зохион байгуулагдаж ирсэн уламжлалт арга хэмжээ болох төр төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан хууль зүйн мэдээллийн цаг арга хэмжээг 2018 оны 4-р сарын 18-ны өдөр зохион байгуулах хуваарийн дагуу төр төсвийн байгууллага тус бүрт зохион байгуулж, 2018 онд хэрэгжих төсөл хөтөлбөр, жижиг зээлийн талаарх мэдээллийг хүргэж нийт 70 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа.

МУ-ын төрийн дээд шагнал “Алтан гадас”-одонт, Монгол улсын тэшүүрийн спортын мастер, Боловсрол, Биеийн тамирын тэргүүний ажилтан, Ахмад багш Гомбосүрэнгийн Дагвын нэрэмжит “Орхон бүсийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн гар бөмбөгийн тэмцээн”-ийг 03-р сарын 31-ээс 04-р сарын 1-нд зохион байгуулж, нийт 14 багийн 120 орчим тамирчид авхаалж самбаа хурд хүчээ сорин оролцож Орхоны 1-р баг түрүүллээ.

2018 оны 03 сарын 29-ны өдрийг “Бүх нийтийн их цэвэрлэгээний өдөр” болгон зарласантай холбогдуулан тус ажлын хүрээнд айл өрх, аж ахуй нэгж байгууллагууд ойр орчмын 50-100м газрын хог хаягдалаа цэвэрлэн, төр төсвийн 5 байгууллагын 78 албан хаагч сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн 10 га газрын ил задгай гялгар уут, хуванцар, цаасны хог хаягдал болон малын сэг зэмийг устгах ажил хийгдлээ. Нийт 3 байгууллага, 18 айл өрхийн 20тн хог хаягдлыг сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөх ажил хийгдлээ.

Сумын хэмжээнд мал төллөлт хэвийн явагдаж оны эхний нийт хээлтэгчийн 60,2 хувь төллөөд байна Гарсан төлийн 98,1 хувь бүрэн бойжиж төлийн хорогдол 1,8 хувьтай, том малын хорогдол 0,5 хувьтай байна. Сумын 800 дээш толгой малтай өрхийн нийт 18 өрхийн судалгаа, 60 дээш толгой үхэртэй цөөн богтой 17 өрхийн судалгаа, 2018 онд бэлтгэх сүүний судалгаа өрхийн тоо, дундаж үнийн судалгааг гаргалаа. “Монгол Ви И Ти Нет” ТББ-аас малчдын дунд явуулсан мал эмнэлгийн сургалтанд малчид, мал бүхий 37 иргэнийг хамруулсан.

Хаврын тариалалтын ажилтай холбогдуулан тариалангийн талбайд оготно устгалын ажил хийхтэй холбогдуулан тариалангийн талбайн ойр орчим байгаа айлуудад 73 албан мэдэгдэл хүргүүлсэн.

Орхонтуул сум:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж ажиллалаа.

Энэ сард сумын ИТХ-н 11 дүгээр хуралдаанаар төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Төрийн албан хаагчийн сургалт, солилцоо” дэд хөтөлбөр, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” гэсэн 2 хөтөлбөрийн төслийг боловсруулсан батлуллаа.

Төсвийн тухай хууль болон Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж санхүүгийн зөрчилгүй байгууллага, сум болох зорилт тавьж сумын Засаг даргын “Ажил сайжруулах тухай” 1 сарын хугацаатай 01 тоот албан даалгавар гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Энэхүү албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн шууд захирагчид, нягтлан бодогч, нярав зэрэг албан хаагчдыг хамруулан Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын Засаг даргын Тамгын газрын газарт Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах ажил явагдаж байна.

Энэ сард шинээр 8 хүүхэд төрж, гэрлэлт 1, нас баралт 3 бүртгэгдсэн байна. Шилжиж явсан-15, шилжиж ирсэн-20 иргэн байна.

Сайн дурын даатгалд шинээр 12, эрүүл мэндийн даатгалд 32 иргэнийг хамруулж дэвтэрт нь баталгаажуулалт хийгдлээ. Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 04-р сарын 24-ний өдрийн байдлаар 8560,0 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 1622,8 мянган төгрөгийн хураамжийн орлого орсон байна. Тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож, өр, авлага барагдуулах ажлын хүрээнд 1 аж ахуй нэгжийн 172,5 мянган төгрөг, төсвийн байгууллагын 84,5 мянган төгрөгийн өр авлагыг барагдуулсан байна.

Тайлант сард хөдөө малчдаар 3 удаа явж нийт 134 малчин өрхөөр орж мал хаваржилт, төл бойжилтын ажил байдалтай танилцаж малчдын санал хүсэлтийг сонсож цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөж хавар болж өвөлжөө хаваржаанаас нүүж байгаа тул хот орчмын ариун цэврийг сахих ажлыг хийж хэрэгжүүлэхийг мэдэгдэн ажиллалаа. Бусад аймаг сумын нутгаар хил залгаа нутаглаж байгаа нийт 16 малчин өрхөөр шүлхий өвчний мэдээллийг хүргэн тухайн нутаг дэвсгэрт гаднаас мал орж ирэх мөн өөрсдөө гадагш малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх талаар санамж сэрэмжлүүлэг өгч байна.

04-р сарын 20-ны байдлаар сумын хэмжээндт өллөх 85975 толгой хээлтэгчээс 50506 толгой хээлтэгч мал төллөж мал төлөлт 58,7%- тай, гарсан төлийн 99,2 хувь нь буюу 50261 толгой төл бойжиж байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяны хүрээнд малын сэг зэм устгах ажлыг хэрэгжүүлэн нийтийн эзэмшлийн нутаг дэвсгэрт үхсэн малын сэг зэмийг цуглуулж ачиж зориулалтын газар устгал хийж ажиллалаа. Сумын төв тойрсон нийт 368 сэг зэмийг цуглуулж устгал хийсэн.

2018 онд тариалалт хийхээр бэлтгэл ажил засварын ажлыг гүйцэтгэж, аж ахуйн нэгжүүд талбайн чийг хаалт хийх ажлыг гүйцэтгэж нийт 6500 га-д чийг хаалт хийгээд байна.

Сумын 24-р цэцэрлэгээс Хүүхэд нэг бүрийн ур авъяасыг хөгжүүлэх, дуулах ур чадварыг нэмэгдүүлж уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах зорилгын хүрээнд энэ сарын 19-ны өдөр Сайхан суманд зохион байгуулагдсан “Гэрэлт ирээдүй-2018” дууны тэмцээнд Рашаант тосгоны ахлах бүлгийн 21 хүүхдийг дуу, шүлэг, хөгжмийн төрлөөр оролцуулж, хөгжмийн төрлөөр мөнгө, хүрэл медаль, шүлгийн төрлөөр алт, хүрэл

медаль болон тусгай байрын шагнал, дууны төрлөөр хүрэл медаль, тусгай байрын шагнал тус тус эзэлсэн байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль Улсын төрөлжсөн 2-ын даваанд багш, сурагчид амжилттай оролцож, сэтгэх чадварын хичээлээр 3-р ангийн сурагч О.Билэгт-Оюу 2-р байр, 7-р ангийн сурагч Х.Сэнгэ-Очир 3-р байр, 10-р ангийн сурагч Д.Хөлөгмөрөн 3-р байр, 12-р ангийн сурагч Н.Оюунбилэг 3-р байр, физикийн хичээлээр 12-р ангийн сурагч Н.Оюунбилэг 5-р байр тус тус эзэлсэн.

Тайлант сард Рашаант Эрүүл мэндийн төвд нийт 506 үзлэг хийгдснээс урьдчилан сэргийлэх үзлэг-144, амбулаторийн үзлэг-188, идэвхтэй хяналтаар-17, гэрийн эргэлт-85, дуудлага-72 үүнээс алсын дуудлага 25 байна.Жирэмсний хяналтанд 10 эх хянагдаж, өөрийн0 эмнэлэгт 2 эх төрсөн.

Энэ сард сумын Соёлын төвөөс “Заавал сурах 10 бүжгийг хэн сайн бүжиглэх вэ” тэмцээн, Дунгийн эгшиг яруу найргийн тэмцээн, Гэр номын сан уралдаан болон СТА Энхзул, Чинбаяр нарын Аз жаргалын цэцэг тоглолт зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Соёлын төвийн Бүжгийн дугуйланд 20 сурагч, насанд хүрэгчид 12 хамрагдан заавал сурах 10 бүжиг, хуучин бүжгүүдийг сэргээн сануулах, уралдаан тэмцээнд бэлтгэх зэргээр үйл ажиллагаа явуулж байна.

Сант:

Сумын хэмжээнд 04 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар төллөвөл зохих 41207 эх малаас 26083 толгой мал төллөж, мал төллөлт 63,3 хувьтай байна. Үүнээс адуу 164, үхэр 219, хонь 15100, ямаа 10600 төллөж, төл бойжилт 99,8 хувь буюу 26053 төл бойжиж байна. Том малын зүй бус хорогдол адуу 6, үхэр 86, хонь 45, ямаа 29 бүгд 166 том мал хорогдсон нь нийт малын 0,2 хувийг эзлэж байна.

Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай сумын Засаг даргын 2018 оны А/18 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан сэг зэм устгалын ажил хийгдэж адууны 2, үхрийн 31, хонины 3, нохойны 1 нийт 37 сэг зэмийг нэгдсэн цэгт төвлөрүүлэн булж устгасан. Бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах, төлбөр авах тухай болон туслах малчны буюу ажиллах хүчний хэрэгцээ шаардлагын талаар 50 малчин өрхөөс санал асуулга авч дүнг нэгтгэн аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт явуулсан байна. “Монгол Ви Ти Нет” ТББ-тай хамтран орон нутгийн малын эрүүл мэнд сургалтыг зохион байгуулж малчдад хөнгөлөлттэй нөхцлөөр эм тариа худалдаалах, өвчтэй зарим малыг оношлуулах, гарын авлага материалаар хангах ажлыг хийж сургалтанд нийт 64 малчин, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Улсын тариаланчдын зөвлөгөөн”-д тус сумаас 2 аж ахуйн нэгжийн төлөөлөл, нэг ногоочин, нэг жимс жимсгэнэ тариалагч иргэн оролцсон.

Сумын 90 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд “Эрүүл орчин, хог хаягдал, соёлжилт, тохижилт, ногоон байгууламж” 90 хоногийн аяныг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж “Соёлч өрх”, “Шилдэг тохижилттой аж ахуйн нэгж байгууллага”, “Шилдэг тохижилттой гудамж” шалгаруулах болзолт уралдааныг зарлан явуулж байна. 4-р сарын 06-07-ны өдрүүдэд бүх нийтийн хог цэвэрлэгээг хийж нийт 18 аж ахуйн нэгж байгууллага, 170 иргэн оролцож 55 га талбайн 128 м.куб хогийг хогийн цэгт тээвэрлэн хаясан байна. Төр төсвийн байгууллагууд нийтийн эдэлбэрийн хуваарьт газруудаа цэвэрлэсэн ба ЗДТГ-ын албан хаагчид сумын төвөөс Орхон голын эрэг болон зам дагуух хуримтлагдсан хогийг цэвэрлэж зайлуулсан байна. Энэ ажилд сумын зорилтот бүлгийн иргэд идэвхтэй оролцож төв хогийн цэг орчмын 6 га газрын гялгар уут, ундааны сав зэргийг түүж 14 м.куб хог цэвэрлэсэн байна.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулагдах тухай аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд сумын хэмжээнд дадлага сургуулийн ажил явагдаж 6 байгууллагын 168 иргэн оролцсон байна. Аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх жижүүрийн хуваарь гарган ажиллаж аймгийн БОАЖГ, ОБГ

болон Сайхан сумын Гал унтраах, аврах 61-р ангид өдөр тутамд шуурхай мэдээллийг өгч байна.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Зөрчлийн тухай хуулийг сурталчилах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор танин мэдэхүйн хөгжөөнт "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд 5 багийн 30 гишүүн, хөгжөөн дэмжигчээр 50 гаруй иргэд хамрагдсан байна. Тэмцээний шагналын санд 200000 төгрөгийн зардал зарцуулагдсан. Мөн зөвлөл, Хүүхэд хамгааллын хамтарсан баг, Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье" сэдэвт сургалт өдөрлөг зохион байгуулж 85 сурагч, 73 эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид хамрагдсан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг "Залуучуудын оролцоог нэмэгдүүлэе" уриан доор зохион байгуулж аяны хүрээнд суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг Монгол газар шим ХХК, Сант Агро ХХК, Норбу агко ХХК, Баяндарь ХХК-ны ажил олгогч, ажилтнуудад ХАБЭА-н тухай хууль, ҮОМШӨ-ний тухай, Аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ, Нийгмийн даатгалын тухай хууль, Газрын тухай хуулиар сургалт зохион байгуулж 44 ажилтан хамрагдсан байна. Нийт ажил олгогч эздэд зориулан ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх соёл, зан үйлийг төлөвшүүлэх, ХАБЭА-н хууль, тогтоомжоор хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэхийг уриалж "Цүнхтэй аян" өрнүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн "Гэгээрэл төв"-тэй хамтран "Ахмад настны тухай хуулийн талаар та мэдэх үү" сэдэвт сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж 25 ахмад настан хамрагдсан байна.

"Татвар төлөгчдийн өдөр"-ийг тохиолдуулан ирээдүйн татвар төлөгчдөд татварын мэдлэг олгох, татвар төлөх нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор ЕБС-ийн ахлах, дунд ангийн 121 сурагчдад "Татвар бидний амьдралд" сэдэвт сургалт мэдээллийг хийсэн. Мөн аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зарласан "Ирээдүйн эзэд" үндэсний мэргэжил сонголтын аяны хүрээнд "Мэргэжил бүхэн сайхан" уулзалт ярилцлагыг сумын Залуучуудын холбоотой хамтран зохион байгуулж ЕБС-ын ахлах ангийн 54 сурагч оролцсон. Мөн аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бүлгээр зөвлөгөө өгөх сургалтанд 9-12 дугаар ангийн 59 сурагч, 29 иргэн хамрагдлаа.

Хушаат сум:

Сумын малчдын зөвлөгөөнийг "Малын чанараа сайжруулж, бэлчээрээ хамгаалж, орлогоо нэмэгдүүлэх боломж" сэдэвтэйгээр 4-р сарын 23-нд зохион байгуулж, 106 малчин оролцлоо. Зөвлөгөөний үеэр "Монголын малчдын холбоо" ТББ, "Монгол малчин" телевизтэй хамтран хэрэгжүүлдэг "Манлай малчин" төсөлд Улс, аймаг, сумын аварга 9 малчныг хамруулж, "Манлай малчин"-ыг алдаршууллаа. Мерси кор ОУБ-аас хэрэгжүүлж буй төслөөс видео танилцуулга хийж, бэлчээрийн төлөв байдлын судалгааны дүгнэлт, цаашид бэлчээр хамгаалах тал дээр анхаарах асуудал, бэлчээрийн даацаас хэтэрсэн малаар хэрхэн Мөнгөн сүрэг бий болгож орлогоо улам нэмэгдүүлэх талаар сонирхолтой туршлага Баян-Өлгий аймагт хэрэгжиж байгаа тухай танилцуулж, Монгол Улсын Зөвлөх мал зүйч Айлтгүй "Хоршиж ажиллахын ач холбогдол" сэдвээр илтгэл мэдээлэл хийлээ. Мөн нийгмийн даатгал, эд хөрөнгийн бүртгэл, эх, олон хүүхэдтэй эцэг эхэд олгох мөнгөн тэтгэмжийн тухай зэрэг хуулиудаар зөвлөмж өгч, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малчин, мал бүхий иргэдийн эдлэх эрх, хүлээх үүрэг, зөвлөгөөний шийдвэр, зөвлөгөөнд тавьсан илтгэлүүд, нийт 712 ш гарын авлагыг тараасан. Соёлын төвийн бүжгийн дугуйлангийн "Болор-2" хамтлаг "Торгууд" бүжгээр мөн хөгжмийн багш ая дууны мэндчилгээ дэвшүүлж үдшийн цэнгүүнийг зохион явууллаа.

Энэ сард төрөлт 7, эцэг тогтоолт 3, шилжин явсан 12 үүнээс баг хооронд 5, аймаг хооронд 6, сум хооронд 1, шилжин ирсний 15 үүнээс баг хооронд 5, аймаг хооронд 3, сум хооронд 7, гэрлэлтийн 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 21, үл хөдлөх

хөрөнгийн эрхийн 3, газар өмчлөх эрхийн 5, иргэний үнэмлэх олголтын 12 нийт 76 бүртгэл хийж 8 гэрчилгээ бичиж олгожээ. Орон нутгийн дансанд 81300, УБСГ-ын дансанд 341500 төгрөгийн орлого оруулсан байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд 32 иргэнийг хамруулан татвар төлөгчид нийт 153358916.8 сая төгрөгийн татварыг буцаан олгохоор боллоо. ХХОАТ-ийн тайлан 185 иргэнээс хүлээн авч татварын тооцоо хийж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд 56 аж ахуйн нэгж байгууллага хамрагдахаас 56 буюу 100% хамрууллаа. Энэ оны 1-4 дүгээр сард нийт 48745.6 сая төгрөгийн төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэл нь 52917.3 буюу 108,5%-ийн биелэлттэй байна. Багийн Засаг дарга нар, татварын улсын байцаагч нар хамтран хөдөө малчдаар явж татварын хуулийг сурталчлан ХХОАТатвар 895,9 төгрөг, татварын бус орлого 3561,2, бууны татвар 210.0 төгрөг, нийт 4667,1 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн санд төвлөрүүлсэн.

Энэ сард гэмт хэргийн шинжтэй 2 хэрэг ажиллагаанд шалгагдаж байгаа ба хүүхдийн тоглоомын талбайд архи уусан, тээврийн хэрэгсэл чирэх журам зөрчсөн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зэрэг 3 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч нийт 95000 төгрөгийн торгууль оногдуулав. Мөн ЭХМ давхардсан тоогоор 45 удаа шалганг 62 иргэнтэй уулзан санамж, сэрэмжлүүлэг тараасан.

Орхон бүсийн ЕБС-иудын дунд сумдын ИТХ-ын нэрэмжит гадаад хэлний олимпиадыг Орхон сумын ЕБС-ийн багш Бямбацэдэнгийн Ганхуягийн анх санаачилснаар 5 дахь жилдээ Хушаат суманд зохион байгууллаа. Орос хэлний хичээлийн олимпиадад 7-9-р ангийн 98 сурагч, англи хэлний олимпиадад 10-12-р ангийн 70 сурагч, нийт 168 сурагч, ИТХ-ын дарга нар, орос, англи хэлний багш сургуулиудын захирал 40 хүн оролцлоо. Багийн нийлбэр дүнгээр англи хэлний төрлөөр Сайхан сум тэргүүн байр, орос хэлний төрлөөр Орхон сум тэргүүн байрыг эзэллээ.

Эрүүл мэндийн төвөөс умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгийн шинжилгээг хөдөөгийн малчи нэмэгтэйчүүдэд хийж, нийт 80 эмэгтэйчүүд хамрагдлаа. Мөн ЕБС-ийн 7-12 дугаар ангийн 45 сурагчид "Шилжилтийн нас ба бэлгийн бойжилт" сэдвээр сургалт хийлээ.

Орхон бүсийн соёл урлагийн ажилтнуудын дунд уламжлал болон зохиогддог "Спортын бага наадам-2018" тэмцээн Хушаат суманд зохион байгуулагдаж 7 сумын баг тамирчид гар бөмбөг, теннис, дартс, шатар, даам, олс таталт зэрэг тэмцээнээр өрсөлдөж байгууллага хамт олноороо нийлбэр дүнгээр Дэд байр эзлэн амжилттай оролцлоо.

ЕБС-ийн "НТБОТ"-өөс "Дүйцсэн хөтөлбөр"-ийн суралцагсдын танхимын сургалтыг 10 хоногийн хугацаагаар зохион байгуулж, "Зөв амьдралын хэв маяг" "Үхрийн махан салат хийх арга" сургалтуудыг зохион байгуулж 42 иргэнийг хамруулсан. Мөн "Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?" сургалтыг 9-12-р ангийн 38 сурагчийг хамруулан зохион байгууллаа.

Сумын Малчдын зөвлөгөөний үеэр 98 иргэнд гал түймрээс урьдчилан сэргийлэх санамж, сурталчилгааны материалыг тараасан ба хөдөөгийн 160 өрхөөр явж санамж тараан гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх морьт эргүүл ажиллуулах хуваарийг 9 хүнд танилцууллаа. Тайлант хугацаанд 1 удаагийн түймэрт 22 иргэн, 3 машин, 5 морьтой иргэн оролцож унтраалаа. Ойн мэргэжлийн 1 байгууллага, 6 ойн нөхөрлөл хамрагдлаа.

Өвөлжөөний тооллого, тэлсэн тариалангийн талбайд хэмжилт хийж сумын ИТХ-д тайлагнасан.

Хүдэр сум:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 2018 оны төсвийн гүйцэтгэлийн 1-р улиралын мэдээ, СХСангийн зээлийн эргэн төлөлт, хяналт шалгалтын тайлан, 2018

оны мод бэлтгэлийн 01-р улиралын гүйцэтгэл, ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг тус тус хэлэлцсэн.

Тайлант сард Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа, сумын Засаг даргын Тамгын газрын хурлыг 2 удаа зохион байгуулж, албан хаагчдад цаг үетэй холбоотой мэдээлэл, хугацаатай үүрэг даалгаваруудыг өгч хэрэгжүүлж ажиллалаа. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, цаашид хийх хэрэгжүүлэх ажил арга хэмжээгээ иргэдэд танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонсох ажлыг зохион байгуулж, нийт 89 иргэн оролцож, мэдээлэл авлаа.

Мөн сумын төрийн албан хаагчдын уулзалт зөвөлгөөнийг зохион байгуулж 130 гаруй төрийн албан хаагчид хамрагдаж, ТАХ-ын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор ХААИС-ийн дэргэдэх сургалтын төвтэй хамтран ТАХ-ын ёс зүй, ТАХ-ын манлайлал, ТАХ-ын мөн чанар сэдвүүдээр сургалтыг зохион байгууллаа.

Эрх зүйн сургалт сурталчилгааг Зөрчлийн тухай хууль, Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлт ба төсөл хөтөлбөр зэрэг сэдвүүдээр хүргэж сургалтанд 151 иргэн 13 аж ахуйн нэгж хамрагдаж, сурталчилгааны материалыг 310 иргэнд тараасан.

Түймрийн аюултай нөхцөл үүсэж байгаатай холбогдуулан Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн 2 чиглэлд хяналтын цэгийг ажиллуулж байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлцгээе” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа 13 аж ахуйн нэгж байгууллага, 29 ажилтныг хамруулан сумын ҮЭ-ийн холбоо, яамны дэрэгдэх Хөдөлмөр сургалтын төвтэй хамтран хөдөлмөрийн ажилтан бэлтгэх сургалтанд хамруулж чадамжийн гэрчилгээг гардуулан ажилласан. Мөн сарын аяны нээлтийг тохиолдуулан суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн төвтэй хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх талаар үзүүлэх сургалтыг явууллаа.

Татварын орлогын төлөвлөгөө 25761,4 мянган төгрөг гүйцэтгэл 19272,4 хувь 74,8 хувьтай, орон нутгийн татварын орлого, төлөвлөгөө 7236,4 гүйцэтгэл 2293,3 биелэлт 31,6 % байна.

Аймгийн Стандарт хэмжлүүрийн хэлтсээс 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, тохирлын гэрчилгээний хугацаа дууссан аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийж, хугацаа хэтэрсэн хүнсний зүйл их гарсантай холбогдуулан энэ сарын 16-нд сумын Засаг даргын удирдамжийн дагуу сумын ажлын хэсэг хүнсний дэлгүүр эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд дахин шалгалтыг хийж, хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, шаардлага хүргүүлж анхааруулга сануулга өгсөн.

Хаврын хуурайшилтын хугацаа эхэлж байгааг холбогдуулж Мод бэлгэлийн аж ахуй нэгжүүдэд Ойгоос мод бэлтгэх ажлыг 2018 оны 03 дугаар сарын 20 ны өдрөөр дуусгавар болгож ойн цэвэрлэгээний ажлыг хийж актаар хүлээлгэж өгөх тухай албан мэдэгдэл гаргаж 20 аж ахуй нэгжид тарааж, БОХУБайцаагч нар Монгол алт, Шоргоолж, Зэрлэг чиглэлд талбай тусгаарлалт хийсэн аж ахуй нэгжүүдийн ойн цэвэрлэгээний ажлыг хэрхэн хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж ажилласан.

Тайланд сард төрсний бүртгэлд 4 хүүхэд бүртгүүлж РД олгосноос эрэгтэй 3, эмэгтэй 1 хүүхэд гэрчилгээ авсан. Мөн нөхөн эцэг тогтоолтын бүртгэл 1 хүүхэд хийгдсэн. 16 нас хүрсэн 4 иргэн, 25, 45 насны сунгалт хийлгэсэн 19 иргэн байна. Үүнээс гадна цахим үнэмлэхээ гээгдүүлсэн 4 иргэн үнэмлэхээ захиалж, хэвлэгдэн ирсэн 24 иргэний цахим үнэмлэхийг олгосон байна. Өөр аймаг, сумаас шилжин ирсэн 10, баг хооронд шилжсэн 2, шилжиж явсан 8 иргэн байна. Гэрлэлтээ батлуулсан 1 хос байна. Нас барсны бүртгэлд 1 иргэн тус тус бүртгэл хийлгэсэн болно. 6 иргэний үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар бүрдүүлсэн материалыг хүлээн авч аймагт хүргэж өгсөн. Хэвлэгдэн ирсэн 26 иргэний газрын гэрчилгээг олголоо.

Түшиг сум:

2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаан хуралдаж, хөдөө аж ахуйн тасгаас хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, цаашдын зорилт, байгаль орчны албанаас хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, цаашдын зорилт, сумын 2018 оны төсөвт тодотгол оруулах тухай, 2017 оны Үнэлгээний хорооны ажлын тайлан, 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын эрэмбэлэлт, Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг хэлэлцэн баталлаа.

Засаг даргын Тамгын газрын 18 албан хаагч 04-р сарын 05, 06-ны өдрүүдэд “Хувь хүний хөгжил, манлайлал”, “Сайн засаглал”, “Хөдөлмөрийн харилцаа”, “Цагийн менежмент” зэрэг сэдвээр Улаанбаатар хотод 2 өдрийн сургалтанд хамрагдлаа.

2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 15.00 цагт сумын Соёлын төвд “Химийн бодисын зохистой хэрэглээ” сэдвээр сургалт зохион байгуулж, нийт төр, төсвийн байгууллага иргэд нийт 65 иргэн хамрагдаж, сургалтыг сургагч багш Ц.Баттулга удирдан явууллаа. Энэ үеэр сумын Эрүүл мэндийн төвөөс “Анхны тусламж” сургалтыг явуулж, яс хугаралт, усанд живэлт, түлэгдэлт сэдвээр иргэдэд мэдлэг олголоо.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян арга хэмжээг Соёлын төвд 2018 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулж, төр төсөв, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал” сургалтыг зохион байгууллаа.

04 дүгээр сарын 17нд ахмадуудтай уулзах арга хэмжээг зохион байгуулж, цаг үеийн мэдээллийг хийж, санал хүсэлтийг нь хүлээн авч, шийдвэрлэлээ.

Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг эхний 04-р сарын 20-ны байдлаар төлөвлөгөө 73608.4 мянган төгрөг бол гүйцэтгэл 73608.4 буюу 100%-ийн биелэлттэй байна. 2018 оны орон нутгийн орлого 04-р сарын 20-ны байдлаар төлөвлөгөө 43858.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 14759.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 33.6%-ийн биелэлттэй байна.

Сумын хэмжээнд одоогийн байдлаар малын төллөлтийн мэдээгээр нийт 18822 толгой мал төллөж, мал төллөлт 68%-тай, төлийн хорогдол 201 толгой буюу 0.9%-тай байна.

Төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийг дэмжих, борлуулалтын сүлжээг өргөжүүлэх зорилгоор “Мөнх ногоон тал” ТББ-тай хамтран сургалт зохион байгуулж, 28 иргэнийг хамруулан, Тариалангийн тухай хуулийн дагуу орон нутагт газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжтэй төмс, хүнсний ногоо худалдан борлуулах гэрээг байгуулж ажиллалаа.

Редхилл-Монголия ХХК-тай хамтран хогийн цэгийн гадна болон дотор талын 1.5 га газрын хогийн түрж цэвэрлэлээ. Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тухай 170 иргэнд санамж болон гарын авлага тарааж, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад албан шаардлага хүргүүлж 150 ширхэг түймрийн багаж хэрэгсэл бэлтгүүлээ.

Газар эзэмших, өмчлөх өргөдөл нийт 110 ирснээс газар эзэмших эрхийн гэрчилгээг 8 иргэн 2 аж ахуйн нэгжид бичиж олголоо. Газрын кадастрын хэмжилтийг кадастрын эрх бүхий “Сэлэнгэ Тулга” ХХК –аар 15 айлын газрыг баталгаажууллаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар олгогдсон газраа зориулалтын дагуу ашиглаагүй иргэдэд албан мэдэгдлийг өгч, газрыг хураах, хүчингүй болгох ажлыг гүйцэтгэж байна. Мөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар хэрхэн өмчлөх мэдээллийг 17 иргэнд өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан төрөлжсөн олимпиадад “Монгол хэл”-ний багш Л.Атарцэцэг 1-р байр, “Монгол бичиг”-ийн багш Л.Атарцэцэг 2-р байр, “Математик”- багш Н.Батчимэг 3-р байр тус тус байр эзэлсэн байна. Мөн 04-р сарын 14-нд зохион байгуулагдсан аймгийн “Математикийн цаг сонины нэрэмжит бодлого”-ын уралдаанд нийт 2-5-р ангийн 19 сурагчийг хариуцан сургалтын менежер

П.Оюунжаргал, 6-12-р ангийн 12 сурагчийг хариуцан Н.Батчимэг оролцсоноос багш Н.Батчимэг хүрэл медаль хүртсэн амжилттай байна.

“Сургууль хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат нь шатрын кабинетэд 20 шатар, 20 даам, ханын соронзтой шатар 1ш, 100 буудалт даам 1ш, электрон цаг 1ш, сургалтын хэрэглэгдэхүүн 4 ном, 100 буудалт даамны бодлоготой 2ш ном олголоо.

Эрүүл мэндийн төвийн хамт олон “Олон улсын эмч сувилагч нарын баяр”-ыг угтан зохион байгуулсан Ерөө-Цагааннуур бүсийн тэмцээнд орлцож багаараа 3-р байранд шалгарлаа. ЕБСургуулийн 1-12-р ангийн сурагчдад “Сүрьегүй эрүүл Монгол иргэний төлөө нэгдэцгээ” сэдэвтэй сургалт суртчилгаа зохион байгуулж, нийт 115 сурагч хамрагдаж, анги бүлэг бүрийн эрүүл мэндийн булаэд гарын авлага байрлуулсан байна. “Сүрьегүй Түшигчүүд” сэдэвт спорт тэмцээнийг төр төсвийн байгууллага болон аж ахуйн нэгж, иргэдийн дунд зохион байгууллаа. Нийт 125 хүн хамрагдаж гарын авлага, зөвлөмж тараалаа.

Шаамар сум:

Сумын 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дулаанхаан тосгонд баригдах “Ахмадын өргөө”-ний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэсэг тендерийг хуулийн дагуу зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэн явуулдаг “Маргад Монгол” ХХК хуулийн дагуу шалгарсныг захиалагч талд албан бичгээр мэдэгдэж ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хүсэлтийг хүргүүллээ. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээний дагуу 2018 оны 04 дүгээр сарын 20-ноос засварын ажлаа эхлүүлсэн. Сумын ЗДТГ-ын албан хаагчдыг сумын Соёлын төвийн номын санд төвлөрүүлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.

Сумын нийт ногоочид, тариалан эрхлэгч иргэдийн дунд “Өрхийн түвшинд жимс, хүнсний ногоог тариалах чадавхийг сайжруулах нь” сэдэвт зөвлөгөөнийг 3-рс сарын 30-нд сумын Соёлын төвд зохион байгуулж, газар тариалан эрхэлдэг нийт 170 гаруй тариаланч оролцож, Дархан-Уул аймгийн УГТЭСШХ-тэй хамтран хаврын хөрс боловсруулалт, тариалалтыг цаг хугацаанд нь чанартай хийх, хүнсний ногооны тариалалт, хөрсний хамгаалалт, хамгаалагдсан хөрсний боловсруулалт, зарим ногоог хүлэмжээр тариалах талаар арга зүйн зөвлөмж өгч, санал бодлоо солилцлоо.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэлхийн өдөр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ны нээлтийн үйл ажиллагааг суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг түшиглэн 4-р сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд сумын ЗДТГ, ЕББДС, МСҮТ, 18 дугаар цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, “Алтанбилэг” уурын зуух, 2 дугаар цэцэрлэгийн уурын зуух, “ЭМ ЖИ ЭЛ БИ” ХХК зэрэг төрийн болон төсөвт байгууллагын нийт 7 аж ахуйн нэгж байгууллагын 70 гаруй ажиллагсад, оюутнууд оролцож, МСҮТ-ийн багш нар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, осол гэмтэлд өртсөн тохиолдолд хэрхэн анхан шатны тусламж үзүүлэх дадлага сургалтыг үзүүллээ.

Сумын нутаг дэвсгэрт цэвэр орчин бүрдүүлэх, орчны эрүүл ахуйн байдлыг сайжруулж, хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор 4-р сарын 12,13-ны өдрүүдэд төр төсвийн байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн дунд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Үүнд: 10 байгууллага, 4 аж ахуй нэгж, 4 нөхөрлөл, 7 дэлгүүрийн 254 ажилтан албан хаагчид, 120 гаруй айл өрхийн иргэд гудамж талбайгаа цэвэрлэж 48 тэвш хогийн цэгт хаяж устгасан байна.

Сумын сүсэгтэн олны шүтээн Ээж модны “Хаврын баяр-Ханш нээх” арга хэмжээг угтан Сэлэнгэ аймгийн хил залгаа орших аймаг сумдад мал амьтны гоц халдварт “А” зэрэглэлийн шүлхий, цэцэг өвчин гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын А/33 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар ханган урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйжүүлэлтийн хяналтын түр цэгийг Дулаанхаан тосгоны 4 замын постонд 2018 оны 04 сарын 03-ны

өдрөөс 04 сарын 08 өдрийг хүртэл 5 хоногийн хугацаатай ажиллууллаа. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал эмнэлэгийн 3 малын эмч ээлжээр ажиллаж нийт 1571 машинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж үйлчилгээний төлбөрт 1.5 сая төгрөг хураан төвлөрүүлж, үйл ажиллагааны зардалд 510,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Сумын мал эмнэлэг үржлийн нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, хяналт тавих зорилгоор Сэлэнгэ аймгийн Мал эмнэлэгийн алба, сумын Засаг дарга, сумын Мал эмнэлэг үржлийн нэгжтэй гурвалсан гэрээг байгуулж мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4 төрлийн вакциныг татан авсан. Сумын Бүх нийтийн цэвэрлэгээний ажлын үеэр малын сэг зэм устгах ажлыг ХАА-н тасгийн малын эмч, мал зүйч нар хамтран зохион байгуулж 29 бод, 7 бог нийт 36 малын сэг зэмийг хогийн төвлөрсөн цэгт бөөгнүүлэн шатааж экоцит ариутгалын бодисоор халваргүйжүүлэлтийг хийж булж устгасан байна.

Сумын малын хорогдол 2018 оны 01 дүгээр улирлын байдлаар өссөн дүнгээр 49 толгой мал байна. Нийт төллөх малын 69,3 хувь төллөж үүнээс унага 43, тугал 2059, хурга 2601, ишиг 2513 төллөсөн ба тугал 12, хурга 17, ишиг 13 хорогдож нийт 7114 толгой төл бойжсон байна.

Шаамар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 04 сарын 29-ны өдрийн 30 тоот “Сум орон нутагт гадны малтай иргэн буухыг хориглох тухай” тогтоолын дагуу малын бэлчээрийн даацыг тохируулах үүднээс суманд зөвшөөрөлгүй буусан 5 малчин өрхийг Алтанбулаг сумын удирдлагуудтай хэлэлцэн хэлцэл хийж хөдөө нуурлуу зусуулахаар шийдвэрлэлээ.

Тариалангийн хуулийг хэрэгжүүлж тариалангийн 1200 га талбайн хөрсийг шинжилгээнд хамруулж, газар тариалангийн хаврын бэлтгэл хангалт 86 хувьтай, тарианы үрийг бэлтгэн үр нарлуулах ажил хийгдэж байна. Техник засвар 95 хувьтай засварын ажил дуусах шатандаа явж байна. Хүнсний ногооны үрслэг бойжуулах ажилд 160 гаруй өрхийн 2120 м2 талбайд 5-6 нэр төрлийн хүнсний ногооны үрслэг бойжуулж байна.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нэг хүүхэд-Нэг байгууллага”, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэе” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан сумын ЕББДС, 18 дугаар цэцэрлэг, Баясгалант Ирээдүй 2 дугаар цэцэрлэг зэрэг албан байгууллагуудад тараан өгч арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн сумын залуучуудын судалгаа, хүүхдийн аж байдлын судалгаа, хөгжлийн бэлхшээлтэй хүүхдийн нарийвчилсан судалгаа, архины хамааралтай иргэдийн судалгаа зэргийг нэгтгэн гаргаж аймгийн ХГБЗХ-ийн газари хүргүүлэн ажиллалаа.

2018 оны 4 дүгээр сарын байдлаар Шаамар сумын 1,2 дугаар багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй 1, эмэгтэй 1 хүүхэд төрж, нийт 2 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгосон. Гэрлэлтээ батлуулах хүсэлт гаргасан 1 иргэний бүртгэн гэрчилгээ олгож, нас барсан 2 иргэний бүртгэлийг хийж гэрчилгээг тус тус олгосон. 2018 оны 3 дугаар сарын байдлаар бусад аймаг хотруу шилжин явсан 7 иргэн, бусад аймаг, сумаас 3 иргэн өөрийн хүсэлтийн дагуу шилжин ирсэн.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА